



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



“ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

БАНКНЫ ЭРХ ЗҮЙ

Оюутны гарын авлага

Зөвлөх: Д.Дүгэржав

Зохиогчид: Ч.Сарангэрэл
З.Оюунцацрал
Ч.Баяртуул

*Энэхүү гарын авлагыг Хууль зүйн яатнаас хэрэгжүүлж буй
Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах”
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар хот
2013 он

DDC
346.082
Б-26

БАНКНЫ ЭРХ ЗҮЙ ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

Хөтөлбөр, гарын авлага боловсруулсан баг:

Зөвлөх:

Д.Дүгэржав

Зохиогчид:

Ч.Сарангэрэл

З.Оюунцацрал

Ч.Баяртуул

Хэвлэлийн хуудас: 8.0

Цаасны хэмжээ: В5

Хэвлэсэн тоо: 1200

Хэвлэсэн газар: “BCI” Хэвлэлийн компани

ISBN 978-99962-56-72-1



Даш-Онолтын ДҮГЭРЖАВ

*“Эм Ди Эс энд Ассошейтс” ЗГБХН-ийн Ерөнхий
партнер*

Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн бөгөөд Дэд тэргүүн, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо ТББ-ын үүсгэн байгуулагч, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-ын үүсгэн байгуулагч.

1982 оноос эхлэн Прокурорын байгууллагад мөрдөн байцаагч, прокурор, хэлтсийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны мэргэжилтэн, Санхүү, эдийн засгийн дээд сургуульд багш, дэд захирлаар ажиллаж байсан. Эдийн засгийн харилцааны суурь хуулиуд болох Иргэний хууль (1994 болон 2002), Компанийн тухай хууль (1999 болон 2011), Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай зэрэг хуулийн төслийг боловсруулахад оролцож олон тооны сурах бичиг, гарын авлага, өгүүлэл бичиж нийтлүүлсэн. Хуулийн фирмээ үүсгэн байгуулахаас өмнө Санхүүгийн зохицуулах хорооны Дэд дарга бөгөөд орон тооны гишүүнээр ажиллаж байсан. Бизнесийн эрх зүй, санхүү, үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтын чиглэлээр мэргэшсэн.




Чулуунбатын САРАНГЭРЭЛ

*Хууль зүйн магистр
Улсын Их Хурлын Дэд даргын зөвлөх*

Украин Улсын Тарас Шевченкогийн нэрэмжит Киевийн Их Сургуулийн Олон Улсын Харилцааны Дээд Сургуулийг 2002 онд Олон улсын эрх зүйч мэргэжлээр төгсч, 2005 онд Отгонтэнгэр Их Сургуульд Хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан.

Олон улсын хувийн эрх зүй, иргэний эрх зүйн чиглэлээр мэргэшсэн.

**Зоригтын ОЮУНЦАЦРАЛ***Бизнесийн удирдлагын магистр**СЭЗДС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн эрхлэгч,*

СЭЗДС-ийг 1995 онд Банк, зээлийн эдийн засагч мэргэжлээр төгсч, 2003 онд Солонгосын Handong Global University and IFE joint MBA хөтөлбөрт магистрын зэрэг хамгаалсан, 2010 оноос СЭЗДС-ийн докторын хөтөлбөрт суралцаж, СЭЗДС-д 18 дах жилдээ багшилж байна.

Банкны менежмент, банкны аудит, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн.

**Чимэд-Очирын БАЯРТУУЛ***Хууль зүйн ухааны магистр**Монгол Улсын банк, санхүүгийн тэргүүний ажилтан.*

1996 онд МУИС-ийн Хууль Зүйн дээд сургууль, 1998 онд магистрантурыг тус тус төгссөн.

1996 оноос Улсын Ерөнхий Прокурорын Газар, 1999 оноос Монголбанк, 2012 оноос Бодь Интернэшнл ХХК-ийн ахлах хуульч, “Де Юре партнерс” ХХК-ийн үүсгэн байгуулагч, Сургалт хариуцсан партнер, “Томбодорж партнерс” ЗБН-ийн Ерөнхий партнер, үнэт цаасны зах зээл дээр ажил үйлчилгээ явуулах эрх бүхий хуульч,

1996 оноос хуулийн болон эдийн засгийн их, дээд сургуулиудад үндсэн болон зочин багшаар ажиллаж байна.

2002 онд Орхон Их Сургуулийн багш, хууль зүйн ухааны мастер Д. Батаагийн хамт “Монгол улсын банкны эрх зүй”-н сурах бичгийг нийтийн хүртээл болгосон.



ӨМНӨТГӨЛ

Зах зээлийн нийгэмд та бид өдөр тутам төлбөрийн карт ашиглах, мөнгө шилжүүлэх, харилцах данс нээлгэх, хадгаламж эзэмших, зээл авах зэргээр банктай эрх зүйн харилцаанд оролцож байна. Хууль зүйн бакалаврын түвшинд бэлтгэгдэж буй эрх зүйчид банкны систем, түүний бүтээгдэхүүн, үйлчилгээний эрх зүйн зохицуулалтын талаар мэдлэгтэй, холбогдох хууль тогтоомжийг зөв хэрэглэх чадвартай байх хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгарч байна.

Энэхүү сургалтын гарын авлагад банкны эрх зүйн онолын үндсэн асуудлыг удиртгал, банкны төрөл, үйл ажиллагаа, банкны хөрөнгө, төв банк ба харилцагчийн эрх ашиг, банкинд хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээ гэсэн бүлэг сэдвийн хүрээнд авч үзсэн болно. Мөн оюутанд онолын мэдлэгээ бататгах дадлага ажил болон банкны хууль тогтоомжийг хэрэглэх чадварыг эзэмшүүлэх зорилгоор тодорхой дасгал, тохиолдол, бодлогыг оруулсан болно.

Банкны эрх зүйн хичээлийн гарын авлага боловсруулан хэвлүүлж, нийтийн хүртээл болгох ажилд дэмжлэг үзүүлсэн Хууль зүйн яамнаас хэрэгжүүлж буй Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хамт олонд талархал илэрхийлье.

Зохиогчид

ГАРЧИГ

I ХЭСЭГ. БАНКНЫ ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР	7
1. Банкны эрх зүй хичээлийн тодорхойлолт	7
2. Банкны эрх зүй хичээлийн товч агуулга, эх сурвалж	10
II ХЭСЭГ. БАНКНЫ ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА.....	19
I БҮЛЭГ. УДИРТГАЛ	19
1. Банкны эрх зүй, банкны мөн чанар, банк байгуулах тусгай зөвшөөрлийн эрх зүйн зохицуулалт.....	19
2. Компанийн засаглал ба банк.....	22
II БҮЛЭГ. БАНКНЫ ТӨРӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	26
3. Банкны үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт	26
4. Банкны төрөл, санхүүгийн олон улсын байгууллагууд.....	37
III БҮЛЭГ. БАНКНЫ ХӨРӨНГӨ	39
5. Банкны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа.....	40
6. Банкны актив, пассивын удирдлага	44
IV БҮЛЭГ. ТӨВ БАНК БА ХАРИЛЦАГЧИЙН ЭРХ АШИГ	47
7. Төв банк, түүний үйл ажиллагаа.....	48
8. Банкны харилцагч, түүний эрх ашиг	51
9. Банкны үйл ажиллагаанд тавих хяналт	58
10. Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь.....	65
V БҮЛЭГ. АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ.....	70
11. Банкинд хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээ.	71
III ХЭСЭГ. БАНКНЫ ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ЗААХ АРГА ЗҮЙ.....	77
1. Хичээлийн заах арга зүйд тавигдах шаардлага.....	77
2. Банкны эрх зүй хичээлд хэрэглэгдэх зарим арга зүй	77



I ХЭСЭГ. БАНКНЫ ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

1. БАНКНЫ ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Банкны эрх зүй хичээлийн танилцуулга

Боловсролын түвшин:	Эрх зүйн бакалавр
Индекс:	*****
Судлах улирал:	8 дугаар улирал
Кредит цаг:	2
Судлах цаг:	40 цаг /лекц 24 цаг, семинар 16 цаг/
Залгамж холбоо:	Энэхүү хичээлийг Эдийн засгийн онол, Иргэний эрх зүй, Бизнесийн эрх зүй хичээлийн дараа Үнэт цаасны эрх зүй, Нягтлан бодох бүртгэл хичээлүүдтэй зэрэгцүүлэн судалбал зохино.

№	Өмнө болон зэрэгцүүлэн судлах хичээл	Үндэслэл
1	Эдийн засгийн онол	Эдийн засгийн онол хичээлээр макро болон микро түвшинд эдийн засгийн үйл ажиллагааны хөгжил, хөдөлгөөн, механизмын зүй тогтлыг судалдаг билээ. Банк, банкны системийн үйл ажиллагаа, чиг үүрэг макро болон микро эдийн засгийн үйл явцтай нягт холбоотой юм.
2	Иргэний эрх зүй	Хувийн эрх зүйн үндсэн салбар болох иргэний эрх зүй нь бусад салбар эрх зүйг гүнзгийрүүлэн судлах суурь юм. Иргэний хуульд мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцооны үүрэг зэрэг банкны үндсэн үйл ажиллагааны зохицуулалт тусгагдсан байдаг.
3	Бизнесийн эрх зүй	Бизнесийн эрх зүй хичээлээр бизнес эрхлэх хэлбэрүүд, ашгийн төлөө үйл ажиллагаа, харилцагчийн эрх ашгийг хамгаалах зэрэг харилцааны эрх зүйн зохицуулалтын тухай мэдлэг олгодог. Банк тусгай зохицуулалт бүхий компани учир бизнесийн эрх зүйн хичээл нь банкны эрх зүй хичээлийг судлах нэг суурь болно
4	Үнэт цаасны эрх зүй	Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулагчийн үнэт цаас, мөнгөн хөрөнгийг бүртгэн, найдвартай хадгалах, захиалагчийн даалгаврыг гүйцэтгэх болон бусад үйлчилгээг кастодиан банкнаас үзүүлэх тул үнэт цаасны эрх зүй хичээлийг эхэлж буюу зэрэгцүүлэн судалж болно.

5	Нягтлан бодох бүртгэлийн үндэс	Банк бизнесийн байгууллагын онцлог бүхий төрлийн хувьд үйл ажиллагаа, ажил гүйлгээ бүрийг нягтлан бодох бүртгэлд тусган харуулах үүрэгтэй байдаг. Банкны санхүүгийн тайлагнал тодорхой, ил тод, стандартын дагуу байх тусам түүнд тавих хөндлөнгийн болон Төв банкны хяналт үр ашигтай байж, санхүүгийн тогтвортой байдал хангагдах боломжтой болно. Иймд банкны эрх зүй хичээлийг судлахад нягтлан бодох бүртгэлийн онцлог, ажил гүйлгээг баримтжуулан бүртгэх үйл явц, санхүүгийн тайлан бэлтгэх талаар суурь ойлголттой байхыг шаардана.
---	--------------------------------	---

Банкны эрх зүй хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага

Өдөр тутмын амьдралдаа та бид банкны төлбөрийн карт ашиглах, мөнгө шилжүүлэх, харилцах данс нээлгэх, хадгаламж эзэмших, зээл авах зэргээр банктай эрх зүйн харилцаанд оролцож байдаг. Зах зээлийн нийгэмд бэлтгэгдэх эрх зүйчид банкны систем, түүний бүтээгдэхүүн, үйлчилгээний эрх зүйн зохицуулалтын талаар мэдлэгтэй, холбогдох хууль тогтоомжийг зөв хэрэглэх чадвартай байх хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгарч байна. Ингэснээр ирээдүйн эрх зүйчид банкны эрх зүйн харилцаанд оролцогчдод хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх, банкны системийн аливаа асуудалд хууль зүйн үүднээс үнэлэлт дүгнэлт өгөх төдийгүй банкны чиглэлээр мэргэшсэн сайн хуульч болж сайхан амьдрах боломж байна.

Банкны эрх зүй хичээлийн зорилго

Оюутан банкны эрх зүй хичээлийг судалснаар улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд санхүүгийн зуучлалын үүргийг гүйцэтгэгч банкны систем, бүтээгдэхүүн, үйл ажиллагаанд хууль зүйн үнэлэлт дүгнэлт өгөхөд шаардлагатай онолын мэдлэгтэй болж, банкны системтэй холбоотой үүссэн харилцаанд банкны хууль тогтоомжийг зөв сонгон хэрэглэх чадвар эзэмшинэ.

Банкны эрх зүй хичээлийн зорилт

Эзэмших мэдлэг:

- Санхүүгийн зуучлалын тогтолцоонд банкны системийн гүйцэтгэх үүргийн тухай;
- Банкны эрхлэх үйл ажиллагаа нэг бүрийн эрх зүйн зохицуулалтын тухай;
- Төв банк, хараат бус байдал, үйл ажиллагааны тухай;
- Банк болоод түүний харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкинд бүтцийн өөрчлөлт хийх, мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай;



Хөгжүүлэх чадвар:

- Банкны эрх зүйн холбогдох хууль тогтоомжийг зөв хэрэглэх;
- Энэ курс хичээлээр олж авсан мэдлэгээ өдөр тутмын амьдралдаа хэрэглээ болгох;

Төлөвших хандлага:

- Банкны систем болон банкны эрх зүйн харилцаанд үүсэж байгаа аливаа асуудалд эрх зүйн үүднээс хандаж мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт өгөх;

Банкны эрх зүй хичээл заах багшид тавигдах шаардлага

Мэргэжлийн талаар:

Их дээд сургуулийн багшид хуулиар тавигдах ерөнхий шаардлагаас гадна банкны эрх зүй хичээлийн онолын суурь мэдлэгтэй, санхүү, бизнесийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын арга зүй болон багшлах дадал, ур чадвар эзэмшсэн, олон улсын түгээмэл хэл дээр эх сурвалж ашиглах чадвартай мэргэжилтэн байвал зохистой.

Заах арга зүйн талаар:

- Лекц унших, семинар болон оюутны бие даалтын ажлыг удирдахдаа бусад салбар эрх зүй болон тухайн хичээлийн сэдэв хоорондын уялдааг оновчтой хангаж, оюутны сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх арга зүйг эзэмшсэн байх;
- Оюутны лекцээр олж авсан мэдээлэл болон бие даан эзэмшсэн мэдлэгт суурилан онолын мэдлэгийг бүтээх үйл явцыг удирдаж чаддаг байх;
- Багш оюутнуудтай хамтран багаар ажиллах чадвартай байх;
- Банктай холбоотой аливаа асуудлыг банкны эрх зүйн үүднээс шийдвэрлэх, цаашлаад иргэн, хуулийн этгээдэд хууль зүйн тусалцаа үзүүлэх чадвартай болоход туслах зорилгоор оюутны идэвхи оролцоог хангасан сургалтын аргуудыг сонгон ашиглаж хэвшсэн байх.

Банкны эрх зүй хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цагийн хуваарилалт

д/д	БҮЛЭГ	Хичээлийн сэдэв	Цагийн бүтэц (лекц/сем)		Нийт цаг
I	УДИРТГАЛ	Банкны эрх зүй, банкны мөн чанар, банк байгуулах тусгай зөвшөөрлийн эрх зүйн зохицуулалт	2 лекц	0 сем	2 цаг
		Компанийн засаглал ба банк	2 лекц	2 сем	4 цаг

II	БАНКНЫ ТӨРӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА	Банкны бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, тэдгээрийн эрх зүйн зохицуулалт	4 лекц	4 сем	8 цаг
		Банкны төрөл, санхүүгийн олон улсын байгууллагууд,	2 лекц	0 сем	2 цаг
III	БАНКНЫ ХӨРӨНГӨ	Банкны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа	2 лекц	2 сем	6 цаг
		Банкны актив, пассивын удирдлага	2 лекц		
IV	ТӨВ БАНК БА ХАРИЛЦАГЧИЙН ЭРХ АШИГ	Төв банк, түүний үйл ажиллагаа	2 лекц	2 сем	4 цаг
		Банкны харилцагч, түүний эрх ашиг	2 лекц	4 сем	10 цаг
		Банкны үйл ажиллагаанд тавих хяналт	2 лекц		
		Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь	2 лекц		
V	АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ	Банкинд хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээ	2 лекц	2 сем	4 цаг
НИЙТ			24 лекц	16 сем	40 цаг

2. БАНКНЫ ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ТОВЧ АГУУЛГА, ЭХ СУРВАЛЖ

I БҮЛЭГ. УДИРТГАЛ

Сэдэв 1. Банкны эрх зүй, банкны мөн чанар, банк байгуулах тусгай зөвшөөрлийн эрх зүйн зохицуулалт

Банкны эрх зүйн ойлголт, эх сурвалж, банкны эрх зүйн зохицуулах зүйл, зохицуулалтын арга, банк, түүний үүсэл, хөгжил, банкны тогтолцооны тухай, банк үүсгэн байгуулах, үйл ажиллагааны зөвшөөрөл олгох эрх зүйн зохицуулалт, энгийн болон нэтэлт зөвшөөрөл.

Сэдэв 2. Компанийн засаглал ба банк

Компанийн засаглал, компанийн сайн засаглалын олон улсын зарчмууд, компанийн тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварын харилцан хамаарал, компанийн засаглалын эрх зүйн зохицуулалт, компанийн засаглалын эх сурвалж, банкны удирдлага-зохион байгуулалтын тогтолцоо, Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, түүний хороод, гүйцэтгэх удирдлага, салбар, газар хэлтэс.



Бүлгийн эх сурвалж:

Нэг. Хууль тогтоомж

1. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль 1995 он
2. Төв банк /Монголбанк/-ны тухай хууль 1996 он
3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль 2002 он
4. Иргэний хууль 2002 он
5. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль 2005 он
6. Банкны тухай хууль 2010 он
7. Компанийн тухай хууль 2011 он
8. Монголын компанийн засаглалын кодекс, Санхүүгийн зохицуулах хороо 2007 он
9. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 594 дүгээр тушаалаар баталсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”
10. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-80 дугаар тушаалаар баталсан “Банкны зөвшөөрлийн журам”

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага

1. Д.Дүгэржав “Монгол улсын санхүү-банкны эрх зүй” 1999 он
2. Д. Наранчимэг “Иргэний эрх зүйн үндсэн асуудал” 1999 он
3. Д. Мөнхдулам, Г.Балж “Банк санхүүгийн үндэс” 2001 он
4. С.Төмөр “Санхүүгийн эрх зүй” 2002 он
5. Н.Баатаржав, З.Оюунцацрал “Монгол Улсын банкны эрх зүй” 2002 он
6. Б.Насанбаяр, А. Цэрэнтоогоо “Банкны үйл ажиллагааны үндэс” 2005 он
7. Д.Дүгэржав “Бизнесийн эрх зүй” 2006 он
8. Т. Цэнд-Аюуш “Компанийн засаглал” 2010 он
9. Олон улсын санхүүгийн корпораци “Компанийн засаглалын ажилтан” 2011 он
10. “Иргэдийн санхүүгийн хөтөч” гарын авлага www.frc.mn
11. Агарков М.М. “Основы банковского права”
12. Ефимова Л.Г. “Банковское право”
13. Олейник О.М. “Основы банковского права”
14. Александр Иконников, Board Solutions Co. & Российская Ассоциация Независимых Директоров, Лидерство в Условиях Нестабильности. Приоритеты Совета, 2009

15. Давид Карапетян, Мария Грачева, Корпоративное управление: основные понятия и результаты исследовательской практики, 2005
16. World Bank, Corporate Governance: A Framework for Implementation, 1999
17. OECD, OECD Corporate Governance Principles, 2004
18. OECD, OECD Guidelines on Corporate Governance of State-Owned Enterprises, 2005
19. OECD, Experiences from the Regional Corporate Governance Roundtables, 2003
20. Commonwealth Business Council Guidelines on Business Principles and Corporate Governance-Edition 1, 2006
21. Mongolia Economic Forum, Risk Report for Mongolia, 2012
22. Jamie Allen, Secretary General, ACGA, History, Principles and Practices of Corporate Governance, 2009
23. Demir Yener, PhD, EPRC Project USAID, Corporate Governance: A Primer, 2010
24. Simon Osborne, GCGF, Board Performance Evaluation, 2008
25. Dr Richard Goddard, ITTF, Corporate Governance. An Independent Director's View, 2011
26. McKinsey & Company, Global Investor Opinion Survey, 2002
27. “Санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчны тулгамдсан асуудал” илтгэлүүдийн эмхэтгэл Санхүүгийн зохицуулах хороо, Азийн хөгжлийн банк, Шихихутуг ХЗС, 2011 он.

II БҮЛЭГ. БАНКНЫ ТӨРӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сэдэв 3. Банкны үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт

Мөнгөн хадгалалж, хугацаатай болон хугацаагүй мөнгөн хадгалалж, мөнгөн хадгалалжийн гэрээний хэлбэр, талуудын эрх, үүрэг, Банкны зээл, үндсэн шинж, зээлийн гэрээ, зээлийн хүү, зээлийн гэрээний үндсэн нөхцөл, зээлийн хувийн хэрэг, ач холбогдол, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа, барьцаалбар, барьцаалбарын бүрдүүлбэр, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, төрөл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч, Төлбөр тооцоо, төлбөр тооцооны харилцааны талууд, төлбөр тооцооны хэлбэр, Төлбөрийн баталгаа гаргах, агуулга, төрөл, талууд, Санхүүгийн түрээс, санхүүгийн түрээсийн харилцааны талууд, санхүүгийн түрээсийн гэрээ, үндсэн нөхцөл, Итгэлцэлийн үйл ажиллагаа, Даатгалын зуучлал, даатгалын зуучлагчид тавих шаардлага, даатгалын компаниатай халтран ажиллах гэрээ, Андеррайтерын үйлчилгээ, Кастодианы үйлчилгээ, Кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээний үндсэн нөхцөл, Факторингийн үйлчилгээ, ач холбогдол, факторингийн үйл ажиллагааны зарчим.



Сэдэв 4. Банкны төрөл, санхүүгийн олон улсын байгууллагууд

Арилжааны банк, Хөрөнгийн урсгал, Хөрөнгө оруулалтын банк, гүйцэтгэх үүрэг, Хөгжлийн банк, онцлог статус, Дэлхийн банк (WB), түүний агентлаг, Азийн хөгжлийн банк (ADB), үйл ажиллагааны чиглэл, Олон улсын валютын сан (IMF), Хяналт шалгалтын Базелийн хороо (BASEL committee on supervisions), үйл ажиллагаа.

Бүлгийн эх сурвалж:

Нэг. Хууль тогтоомж

1. Валютын зохицуулалтын тухай хууль 1994 он
2. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль 1995 он
3. Төв банк (Монголбанк)-ны тухай хууль 1996 он
4. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль 2002 он
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 2002 он
6. Иргэний хууль 2002 он
7. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль 2004 он
8. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль 2005 он
9. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль 2009 он
10. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль 2009 он
11. Банкны тухай хууль 2010 он
12. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль 2010 он
13. Компанийн тухай хууль 2011 он
14. Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль 2012 он
15. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Банкны тухай хуулийн 6.2-г заасан үйл ажиллагааны зохицуулалтын тухай журам”
16. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам”
17. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага

1. Д.Дүгэржав “Монгол улсын санхүү-банкны эрх зүй” 1999 он

2. Л. Оюун. “Үнэт цаас ба арилжааны банк” 2000 он
3. Д. Мөнхдулам, Г.Балж “Банк санхүүгийн үндэс” 2001 он
4. С.Төмөр “Санхүүгийн эрх зүй” 2002 он
5. Н.Батаа, З.Оюунцацрал “Монгол Улсын банкны эрх зүй” 2002 он
6. Б.Насанбаяр, А. Цэрэнтоогоо “Банкны үйл ажиллагааны үндэс” 2005 он
7. “Иргэдийн санхүүгийн хөтөч” гарын авлага www.frc.mn

Гурав. Цахим хаяг:

1. www.wb.org
2. www.adb.org
3. www.ifc.org
4. www.bis.org
5. www.imf.org

III БҮЛЭГ. БАНКНЫ ХӨРӨНГӨ

Сэдэв 5. Банкны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа

Банкны тайлан тэнцлийн бүрэлдэхүүн хэсгүүд, тэдгээрийг тэнцэлд тусгах тухай, Банкны дансны жагсаалт, бүтэц, банкны хөрөнгө, үндсэн чанар, төрөл, Банкны өөрийн хөрөнгийн бүрдүүлэлт, тэдгээрийн үүрэг, нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээ, Эзэмшигчдийн өлч буюу капитал, Оруулсан капитал, Олсон капитал, Хувьцаа, Хувьцаат капитал, Нэмж төлөгдсөн капитал, Хуримтлагдсан ашиг.

Сэдэв 6. Банкны актив, пассивын удирдлага

Актив, пассивын удирдлагын ойлголт, үндсэн шинж, Зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, түүний бүрдүүлэлт, Гадаад төлбөр тооцооны үндсэн ойлголтууд- SWIFT-ийн сүлжээ, түүний үүсэл, хөгжил, ашиглалт.

Бүлгийн эх сурвалж:**Нэг. Хууль тогтоомж**

1. Валютын зохицуулалтын тухай хууль 1994 он
2. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль 1995 он
3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2001 он
4. Банкны тухай хууль 2010 он
5. Компанийн тухай хууль 2011 он



6. Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 дугаар тушаалаар баталсан “Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”
7. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар баталсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”
8. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 245 дугаар тушаалаар баталсан “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам”
9. Монголбанкны баталсан “Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам” 2011 он
10. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 553 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн картын журам”

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага

1. Ш.Эрдэнэцэцэг “Банк санхүүгийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэл” 2008 он
2. Б.Насанбаяр “Банкны нягтлан бодох бүртгэл” 2009 он
3. Т. Туяа “Банк санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэл” 2011 он
4. “Иргэдийн санхүүгийн хөтөч” гарын авлага www.frc.mn

IV БҮЛЭГ. ТӨВ БАНК БА ХАРИЛЦАГЧИЙН ЭРХ АШИГ

Сэдэв 7. Төв банк, түүний үйл ажиллагаа

Хоёр шатлалт банкны тогтолцоо-Төв банкны үүсэл хөгжил, хараат бус байдал, Төв банкны үндсэн үйл ажиллагаа, Төв банк бол мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч, Төв банк бол мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах онцгой эрх бүхий цорын ганц субъект болох нь, Монгол Улсын Төв банк УИХ, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газартай харилцах харилцаа, Монголбанкнаас Эрдэнэсийн санг эрхлэх нь.

Сэдэв 8. Банкны харилцагч, түүний эрх ашиг

Банкны харилцагч (хэрэглэгчийн)-ийн эрх ашиг, харилцагчийн эрх ашгийг хамгаалах эх сурвалж, Мэдээллийн ил тод байдал-хариуцлагатай, үнэн зөв тайлагнал-харилцагчийн эрх ашгийг хамгаалахад чухал нөлөө үзүүлэх нь, Хадгаламжийн даатгал, ач холбогдол, төрөл, зарим улсын хадгаламжийн даатгалд хамрагдах хадгаламжийн хэтжээ.

Сэдэв 9. Банкны үйл ажиллагаанд тавих хяналт

Банкуудын үйл ажиллагаанд тавих хяналт, хяналт шалгалтын төрөл, банкны хяналт шалгалтын тогтолцоо, Төв банкнаас хэрэгжүүлж буй хяналт шалгалт нь төрийн хяналт шалгалт болох нь, хяналт шалгалтын зарчим, банкны дотоод хяналт, дотоод болон гадаад аудит, банкны учирч болзошгүй эрсдэл, төрөл.

Сэдэв 10. Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь

Мөнгө угаах гэмт хэргийн тухай, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага буюу ФАТФ (Financial Action Task Force), Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба (СМА), Монгол улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, Мөнгө угаах гэмт хэргийг банкаар дамжуулан үйлдэх аргууд, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрх зүйн эх сурвалж.

Бүлгийн эх сурвалж:**Нэг. Хууль тогтоомж**

1. Эрдэнэсийн сангийн тухай хууль 1994 он
2. Валютын зохицуулалтын тухай хууль 1994 он
3. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль 1995 он
4. Хувь хүний нууцын тухай хууль 1995 он
5. Байгууллагын нууцын тухай хууль 1995 он
6. Төв банк (Монголбанк)-ны тухай хууль 1996 он
7. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль 2002 он
8. Төрийн хяналт шалгалтын тухай хууль 2003 он
9. Төрийн аудитын тухай хууль 2003 он
10. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль 2003 он
11. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль 2005 он
12. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 2006 он
13. Банкны тухай хууль 2010 он
14. Өрсөлдөөний тухай хууль 2010 он
15. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль 2013 он.
16. Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын зөвлөмжүүд 2003 он



Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага

1. Д.Дүгэржав “Монгол Улсын санхүү, банкны эрх зүй” 1999 он
2. Д.Батаа, Д.Хандсүрэн “Монгол Улсын банкны эрх зүй” 2002 он
3. Ш.Шинэгэрэл “Банкны эрх зүйн үндэс” 2002 он
4. “Иргэдийн санхүүгийн хөтөч” гарын авлага www.frc.mn
5. Жоан Тазир “Аудит, баталгаажуулалт ба ёс суртахууны олон улсын тунхаглалуудын гарын авлага” 2003 он
6. Олейник О.М “Основы банковского права” 1999
7. Олохов Р.Г, Банк и контроль 1991
8. Modelling Nonlinear Economic Relationships (Advanced Texts) 2004
9. Perspectives on the role of central bank 1991
10. Management for central bankers 2000
11. Central banking technical assistance 1994
12. Central bank issues in emerging 1990
13. Central banking and banking regulation 1996
14. “Санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчны тулгамдсан асуудал” илтгэлүүдийн эмхэтгэл Санхүүгийн зохицуулах хороо, Азийн хөгжлийн банк, Шихихутуг ХЗС, 2011 он

V БҮЛЭГ. АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ

Сэдэв 11. Банкинд хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээ

Банкинд авах албадлагын арга хэмжээ, албадлагын арга хэмжээ авах үндэслэл, төрөл, албадлага хэрэглэх зарчим, Банк өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээ зохистой хэмжээнд хүргэх талаар авах арга хэмжээний тухай төлөвлөгөө, Онцгой дэглэл, онцгой дэглэл тогтоох үндэслэл, банкинд учирах үр дагавар, Бүрэн эрхт төлөөлөгч, түүний эрх, үүрэг, Банкныг өөрчлөн байгуулах төлөвлөгөө, Банкны эрх хүлээн авах, эрх хүлээн авах үндэслэл, төлбөрийн чадваргүй банк, Банкинд бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөө, албадан татан буулгах, Банкны эрх хүлээн авагч, бүрэн эрх, авах арга хэмжээ, банкны эрх хүлээн авах ажиллагаа дуусгавар болох, Банкны дампуурал, Хадгалалжийн даатгалын тухай хуулийг хэрэглэх нь.

Бүлгийн эх сурвалж:

Нэг. Хууль тогтоомж

1. Төв банк (Монголбанк)-ны тухай хууль 1996 он
2. Дампуурлын тухай хууль 1997 он

3. Иргэний хууль 2002 он
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль 2003 он
5. Банкны тухай хууль 2010 он
6. Компанийн тухай хууль 2011 он
7. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль 2013 он.

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага:

1. Т.Мөнхжаргал “Аж ахуйн нэгжийн дампуурал” 1993 он
2. Д.Дүгэржав “Монгол улсын санхүү-банкны эрх зүй” 1999 он
3. Т.Мөнхжаргал, Ц.Цолмон “Бизнесийн эрх зүй” 2000 он
4. Д. Мөнхдулам, Г.Балж “Банк санхүүгийн үндэс” 2001 он
5. Н.Баатаржав, З.Оюунцацрал “Монгол Улсын банкны эрх зүй” 2002 он
6. С.Төмөр “Санхүүгийн эрх зүй” 2002 он
7. Д. Батаа, Д.Хандсүрэн “Монгол улсын банкны эрх зүй” 2002 он
8. Б.Насанбаяр, А. Цэрэнтоогоо “Банкны үйл ажиллагааны үндэс” 2005 он
9. Д.Дүгэржав “Бизнесийн эрх зүй” 2006 он
10. “Санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчны тулгамдсан асуудал” илтгэлүүдийн эмхэтгэл Санхүүгийн зохицуулах хороо, Азийн хөгжлийн банк, Шихихутуг ХЗС, 2011 он



II ХЭСЭГ. БАНКНЫ ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

I БҮЛЭГ. УДИРТГАЛ

Бүлгийн зорилго: Банкны эрх зүйг салбар эрх зүйн хувьд авч үзэж, банкны мөн чанар, үүсэл хөгжил, бүтэц зохион байгуулалт, засаглалын тухай мэдлэг эзэмшсэнээр банкны тухай ойлголт гүнзгийрч, банкны хууль тогтоомжийг зөв хэрэглэх, банктай холбоотой асуудалд хууль зүйн үүднээс хандах хандлага төлөвшиж эхэлнэ.

СЭДЭВ 1. БАНКНЫ ЭРХ ЗҮЙ, БАНКНЫ МӨН ЧАНАР, БАНК БАЙГУУЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Сэдвийн зорилго: Банкны эрх зүйн зохицуулах зүйл, зохицуулалтын арга, эх сурвалж, банкны мөн чанар, үүсэл хөгжил, тогтолцоо, банк үүсгэн байгуулах эрх зүйн зохицуулалтын тухай мэдлэг эзэмшинэ.

Түлхүүр үг: Banco /банк/, хоёр шатлалт банкны тогтолцоо, Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк, Монгол банкны хуульчлагдсан акт.

Нэг. Тойм лекц:

Банкны эрх зүйн ойлголт, эх сурвалж, банкны эрх зүйн харилцаа

Банкны эрх зүй нь Төв банк болон банкны үйл ажиллагаатай холбоотой үүсэх нийгмийн харилцааг зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц юм. Банкны эрх зүйн зохицуулах зүйл нь банкны тогтолцоо, тэдгээрийн эрх зүйн байдал, банкны үйл ажиллагаа, мөнгө, санхүүгийн бусад хэрэгслийг ашиглах үйл явцад үүссэн, банкны эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн тодорхой төрлийн харилцаа юм.



Төв банк нийт банкны тогтолцооны зохицуулах, хянах чиг үүрэгтэй учраас банктай харилцах харилцаанд императив зохицуулалтын арга хэрэглэгддэг. Төв банкны бүрэн эрхийн хүрээнд гарсан аливаа шийдвэрийг банкууд заавал дагаж мөрдөнө. Банкны өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд харилцагчтай үүсэх харилцаанд талуудын тэгш байдлыг хангаж, тэдэнд хүсэл зоригоороо зан

үйлийн хувилбарыг сонгох боломжийг олгодог диспозитив зохицуулалтын арга хэрэглэгдэнэ.

ЭХ СУРВАЛЖ	Үндсэн хууль	Үндсэн хуульд олон хэвшил бүхий эдийн засаг, нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлах нийтлэг үндэслэлийг тогтоосон юм.
	Олон улсын гэрээ	Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан Олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн адил хүчинтэй үйлчилдэг.
	Хууль	Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Банкны тухай хууль, Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль гэх мэт нийтлэг эх сурвалж болно.
	Хуульчлагдсан акт	Төв банк өөрийн хуулиар олгогдсон үндсэн зорилтыг хангах, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ заавар, журам, зөвлөмж, тушаал шийдвэр гаргах бүрэн эрхтэй байдаг.
	Зан заншил	Банкны эрх зүйд хэм хэмжээ тогтоосон акттай зэрэгцэн заншил, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг эх сурвалж гэж үзнэ. Тухайлбал: Иргэний хуулийн 449.3-т “Аккредитивийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална.”

Банк, түүний үүсэл, хөгжил, банкны тогтолцооны тухай

Банкны тухай хуулийн 3.1.1-д ““банк” гэж хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээдийг ойлгоно” гэж банкыг хууль зүйн хувьд тодорхойлсон байна.


Банк сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлж, өөрийн нэрийн өмнөөс эдийн засгийн салбаруудад байршуулан мөнгөн хөрөнгийг гүйлгээнд гаргаж мөнгөний салбарын болон салбар дундын хуваарилалт хийх замаар үндэсний эдийн засгийг хөдөлгөгч гол механизм юм. Банк эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр иргэд, аж ахуйн нэгжид санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг.



Түүхийн эх сурвалжид НТӨ III-II мянган жилийн тэртээ банктай төстэй үйл ажиллагаа явуулдаг тухай тэмдэглэсэн байдаг. Худалдааны нэгжүүд, сүм хийдүүд зээлдүүлэх, хадгаламж авч хүү төлөх, мөнгө солих зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг байжээ. Банк хэмээх нэр томъёо Италийн **banco-вандан, мөнгөний ширээ** гэсэн үгнээс гаралтай юм. Банк өнөөгийн утгаараа 14-15 дугаар зуунд Италийн Венеци хотод үүсээд тухайн үеийн худалдааны харилцааны хурдацтай хөгжлийн үр дүнд маш хурдан дэлгэрсэн.

1921 оны Ардын хувьсгалын дараа улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралыг бүхэлд нь өөрчлөхтэй холбоотой олон арга хэмжээг дэс дараатай, системтэй боловсруулан хэрэгжүүлсэн байдаг. Үүний нэг нь 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн хөрөнгөөр Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк /Монголбанк/-ийг байгуулсан.

1991 оны 4 дүгээр сард Улсын Бага Хурлаас Банкны хуулийг баталж төрийн мэдлийн Монголбанк, хувь нийлүүлэгчдийн хувь хөрөнгөөс бүрдсэн банк гэсэн хоёр шатлалтай банкны тогтолцоо бүрдэх суурийг тавьсан.



Банк үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрх зүйн зохицуулалт

Монголбанк банк үүсгэн байгуулах зөвшөөрлийг олгоно. Банкны тухай хуулиар тавигдах шаардлага хангаж байгаа үүсгэн байгуулагч хуульд заасан холбогдох баримт, материалыг бүрдүүлэн Монголбанкинд хүсэлтээ гаргана. (Банкны тухай хуулийн 19, 20 дугаар зүйлийг харна уу).

Монголбанк ирүүлсэн материалыг судлан банк байгуулах зөвшөөрөл олгох асуудлыг 60 хоногт багтаан шийдвэрлэнэ. Монголбанк шийдвэр гаргахдаа шаардлагатай гэж үзвэл нэмэлт материал, мөн шүүх, цагдаа, татвар, аудит, банк, зэрэг байгууллагаас лавлагаа, тодорхойлолт шаардаж болно. Тухайн этгээд банк байгуулах зөвшөөрөл авсны дараа зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

Банкны эрхлэх үйл ажиллагааны зөвшөөрлийг энгийн болон нэмэлт гэж ангилдаг. Банк байгуулах зөвшөөрөл олгосноор энгийн зөвшөөрөл олгогддог. Үүнд: зээл, төлбөр тооцооны үйлчилгээ /зөвхөн бэлэн болон банк хоорондын бэлэн бус/, гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах/, үнэт зүйл хадгалах/, гадаад төлбөр тооцоо хийх/, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхэлж болно.

Үүнээс бусад банкны эрхлэх үйл ажиллагааг нэмэлт зөвшөөрлөөр авна. Банкны тухай хуульд заасан тусгайлсан шаардлагыг хангасан банк нэмэлт зөвшөөрөл авах тухай хүсэлтээ Монголбанкинд гаргана. Хүсэлтэд эрхлэх үйл ажиллагааны нэр төрөл, шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, техник тоног төхөөрөмж, программ хангамж, банкны үйл ажилагаа, санхүү төлбөрийн чадварын үзүүлэлтэд орох өөрчлөлтийн талаар тусгана. Монголбанк хуульд заасан шаардлагыг хангасан банкинд үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг төрөл тус бүрээр олгоно.

Хоёр. Нэмэлт даалгавар

1. “Банк үүсгэн байгуулах зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл, түүний үр дагавар” болон “Монгол Улс дахь банкны үүсэл, хөгжлийн үе шат” сэдвүүдээр бие даалтын ажил гүйцэтгэх.

Хяналтын асуулт:

1. Хоёр шатлалт банкны тогтолцоонд Төв банк болон арилжааны банкуудын гүйцэтгэх үүрэг, хоорондын ялгааг тодорхойлно уу?
2. Банк байгуулах тусгай зөвшөөрлийг олгохоос татгалзах ямар үндэслэл байдаг вэ? Энэхүү татгалзал нь ямар үр дагаварыг бий болгох вэ?
3. Гадаадын иргэн Монгол улсын банкинд хөрөнгө оруулах болон банк байгуулах хүсэлтэйгээр танд хандвал ямар зөвлөгөө өгөх вэ?

СЭДЭВ 2. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ БА БАНК

Сэдвийн зорилго: Компанийн сайн засаглалын олон улсын зарчмууд, компанийн тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварын харилцан хамаарал, компанийн засаглалын эрх зүйн зохицуулалтыг танилцуулж, банкны бүтэц зохион байгуулалтын онцлог, банкны засаглалын тухай цогц мэдлэг эзэмшүүлэхэд оршино.

Түлхүүр үг: Компанийн засаглал, компанийн засаглалын зарчим, банкны удирдлага-зохион байгуулалтын тогтолцоо, банкны зохистой засаглал.

Нэг. Тойм лекц:

Компанийн засаглал

Компанийн засаглал гэдэг нь компанийг хамтдаа засах, чиглүүлэн удирдах тогтолцоог хэлнэ. Компанийн засаглал нь өргөн цар хүрээтэй нарийн ойлголт тул



агуулгын хувьд өөр өөр тодорхойлолтуудтай таарч болох ч дор дурдсан агуулга дээр судлаачид нэгдмэл байр суурьтай байдаг. Үүнд:

- Компанийн засаглал бол бүтэц зохион байгуулалт болон үйл явцаар тодорхойлогдсон харилцааны тогтолцоо юм.
- Компанийн засаглалд өөр өөр, эсвэл харилцан адилгүй ашиг сонирхолтой талууд оролцож болно.
- Оролцогч тал бүр компанийн хяналт болон удирдах үйл явцад ямар нэг байдлаар оролцоно.
- Эрх үүрэг, хариуцлагыг зохистой хуваарилах нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын итгэл үнэмшлийг баталгаажуулна.

Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөгжлийн Байгууллага “шударга байдал-Fairness”, “хариуцлага байх-responsibility”, “ил тод байдал-transparency”, “хариуцлагатай, үнэн зөв тайлагнал-accountability” нь компанийн засаглалын үнэт зүйл-суурь зарчим хэмээн тодорхойлсон.

Компанийн өрсөлдөх чадвар, тогтвортой хөгжил нь түүний засаглалын байдалтай шууд хамааралтай бөгөөд улс орны эдийн засгийн аюулгүй-тогтвортой байдал нь нийт компаниудын засаглалын байдлаас шууд хамааралтай байна.

Өрсөлдөх чадварын 12 тулгуур бүлгийн тэргүүн бүлэг “институцийн тогтолцоо” ордог. Энэ нь компанийн өрсөлдөх чадвар болон өсөлтөнд үлэмж нөлөөтэй бөгөөд хөрөнгө оруулалт хийх шийдвэр, үйлдвэрлэлийн зохион байгуулалт, нийгмийн хариуцлагатай байдал, хөгжлийн стратеги, бодлого, зардлыг зохимжтой байдлаар хуваарилахад гол үүрэг гүйцэтгэнэ. Үүнд компанийн сайн засаглал нь томоохон байр суурийг эзэлсээр иржээ.

Компанийн засаглалын эрх зүйн эх сурвалж нь төрийн эрх бүхий субъектийн баталсан, хууль тогтоомж, хуульд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичиг, тухайн компаниас эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан эрх зүйн баримт бичгээс тус тус бүрдэнэ.

Түүнчлэн тус улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээр, улс орнуудын тэргүүний туршлага бүхий кодексүүд нь компанийн засаглалын эрх зүйн эх сурвалж болно.

Компанийн засаглалын эрх зүйн зохицуулалт:

1. Тухайн улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээр, улс орнуудын тэргүүний туршлага бүхий кодексүүд
2. Үндэсний хууль тогтоомжууд
3. Орон нутгийн засаг захиргааны баталсан дүрэм, журам

4. Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад зориулсан эрх зүйн зохицуулалт, стандартууд,
5. Компанийн дүрэм, журам

Банкны удирдлага-зохион байгуулалтын тогтолцоо

Банк бол эрх бүхий этгээдээс олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр Банкны тухай хуулиар үйл ажиллагаа нь зохицуулагддаг ашгийн төлөө хуулийн этгээд болно.

Хуулийн этгээдийн талаарх онол



Банк нь өөрийн удирдлага-зохион байгуулалтын бүтцийг Компанийн болон Банкны тухай хууль тогтоомжид заасны дагуу батална. Өөрөөр хэлбэл банкны удирдлага-зохион байгуулалтын бүтэц нь дээрх хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн байх учиртай.

Банкны удирдлага-зохион байгуулалтын бүтэц банкны танилцуулгыг, цахим хуудаст байршуулах замаар нийтэд мэдээлнэ. Энэ нь компанийн засаглалын “ил тод байдал”, “хариуцлагатай, үнэн зөв тайлагнал” зарчмын хүрээнд зайлшгүй хэрэгжүүлбэл зохих наад захын арга хэмжээ болно.

Монголбанкнаас “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ыг батлан гаргасан бөгөөд энэ журмын дагуу банкны засаглалын байдалд үнэлэлт дүгнэлт өгч байна.

Банк нь удирдлагын босоо тогтолцоотой байх бөгөөд бүтэц дэх зохион байгуулалтын нэгж (Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, түүний хороод, гүйцэтгэх удирдлага, салбар, газар хэлтэс гэх мэт) нэг бүрийн чиг үүрэг, шууд удирдах нэгж нь тодорхой байвал зохино.



БАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАГВАР



Хоёр. Семинар

Бодлого:

Өгөгдөл: “AAA” ХХК нь “XXX” банкны нийт хувьцааны 25 хувийг өмчилдөг. “AAA” ХХК-ийн нийт хувьцаа бүхэлдээ иргэн Ц-ийн өмч болно.

“XXX” банк нь иргэн Ц бол манай банкны ТУЗ-ийн гишүүн гэж Монголбанкны ээлжит газар дээрх иж бүрэн шалгалтын ажлын хэсэгт танилцуулсан байна.

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалтын дагуу иргэн Ц-г ТУЗ-ийн гишүүнээр томилж эсэх тухай ХЭХ-аар хэлэлцэж, ТУЗ-ийн гишүүнээр томилж, бүрэн эрхийн хугацааг нь тогтоосон тухай тогтоол гараагүй байна.

Мөн банкны танилцуулга, жилийн тайлан, цахим хуудаст “AAA” ХХК нь “XXX” банкны хувьцаа эзэмшигч болох иргэн Ц нь тус банкны ТУЗ-ийн гишүүний тухай мэдээлэл байхгүй байлаа.

Харин Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн хэлтэст банкны дүрэмд орсон өөрчлөлт болох хувьцаа эзэмшигчдийн бүтцийг бүртгүүлэхэд “AAA” ХХК нь “XXX” банкны нийт хувьцааны 25 хувийг өмчилдөг хэмээн бүртгэгджээ. Гэвч “Банкны зөвшөөрлийн журам”-ын дагуу Монголбанкинд бүртгүүлээгүй байна.

Шийдвэрлэх асуудал:

1. Иргэн Ц нь “ХХХ” банкны ТУЗ-ийн гишүүн байх эрхтэй эсэхэд хууль зүйн дүгнэлт гаргах,
2. Иргэн Ц нь “ХХХ” банкны ТУЗ-ийн гишүүн мөн эсэхэд хууль зүйн дүгнэлт гаргах,
3. “ААА” ХХК нь “ХХХ” банкны хувьцаа эзэмшигч болох тухай танилцуулга, жилийн тайлан, цахим хуудаст мэдээлэгдээгүй байгаа нь “ААА” ХХК-ийг “ХХХ” банкны хувьцаа эзэмшигч гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй байна хэмээн хянан шалгагч дүгнэжээ. Хянан шалгагчийн дүгнэлтэд холбогдох хууль зүйн дүгнэлтийг гаргах,
4. “ХХХ” банкны засаглалын ил тод байх зарчмын хэрэгжилтэнд “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу үнэлгээ хийх,

Хяналтын асуулт:

1. Компанийн засаглал гэж юу вэ?
2. Компанийн зохистой засаглал, компанийн тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварын харилцан хамааралын талаар тайлбарлана уу.
3. “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын зорилгыг тайлбарлана уу.

II БҮЛЭГ. БАНКНЫ ТӨРӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бүлгийн зорилго: Санхүүгийн олон улсын байгууллагууд, орчин үеийн банкны төрөл болон банкны үйл ажиллагааны төрөл, эрх зүйн зохицуулалт, зах зээлд нийлүүлж буй бүтээгдэхүүний талаар судалснаар банк, түүний үйл ажиллагаанд хууль зүйн дүгнэлт өгөх чадвартай болно.

СЭДЭВ 3. БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.

Сэдвийн зорилго: Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцоо, итгэлцэл, санхүүгийн түрээс, төлбөрийн баталгаа, даатгалын зуучлал, андеррайтерын үйлчилгээ, кастодиан, факторинг зэрэг банкны үйл ажиллагааны талаар тодорхой мэдлэг эзэмшиж, дээрх бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой асуудалд хууль зүйн үүднээс хандаж, холбогдох хууль тогтоомжийг хэрэглэх чадварыг эзэмшинэ.

Түлхүүр үг: Банкны эрхлэх үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл, хүү, данс, барьцаалбар, санхүүгийн түрээс, төлбөрийн баталгаа, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, даатгалын зуучлал, андеррайтер, кастодиан, факторинг.



Нэг. Тойм лекц: /4 цаг/

Мөнгөн хадгаламж

Банкны нийтэд зарласан хадгаламжийн хүү, хугацааг хүлээн зөвшөөрсөн аливаа этгээдийн (Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд) банкинд гаргасан хүсэлтийн дагуу гэрээний үндсэн дээр мөнгөн хөрөнгийг хадгалж, түүнд хүү төлөхтэй холбоотой харилцааг мөнгөн хадгаламж гэнэ.

Хугацаатай хадгаламж - гэрээ тодорхой хугацаатай байгуулна.	Тохиролцсон хугацаа дуусахаар хадгалуулагчийн анхны шаардлагаар хадгалагч мөнгийг буцаан өгч, хүү төлөх үүрэгтэй.	Хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээг хугацаанаас өмнө банк нэг талын санаачилгаар өөрчлөхгүй, цуцлахгүй. Харин гэрээнд заасан хугацаанаас өмнө хадгалуулагчийн хүсэлтээр цуцлах тохиолдолд хадгаламжийн хүүг гэрээнд заасан хэмжээгээр бууруулдаг.
Хугацаагүй хадгаламж - гэрээ тодорхой бус хугацаатай байгуулна.	Хадгалуулагчийн хүссэн үед банк хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүү төлөх үүрэгтэй.	

Мөнгөн хадгаламжийн гэрээг хадгаламжийн дэвтэр, сертификат болон цахим зэрэг хэлбэрээр байгуулна. Иргэний хууль, Банкны хууль тогтоомж болон мөнгөн хадгаламжийн гэрээнд зааснаар талууд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Хадгалуулагч:

1. хадгалуулсан мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах хэлбэрийг сонгох, хүүгийн орлого авах;
2. мөнгөн хадгаламжийн гүйлгээ, үлдэгдлээ тулгах, шалгах;
3. хугацаатай мөнгөн хадгаламжаас гэрээнд заасан хугацааны дотор зарлагын гүйлгээ хийхгүй байх, зайлшгүй зарлагын гүйлгээ хийх тохиолдолд хадгалагчтай харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулах;
4. мөнгөн хадгаламжийг өвлүүлэх, гэрээслэх, бэлэглэх дундаа хамтран өмчлөх, итгэмжлэл олгох;
5. хадгалагчаас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэх;

Хадгалагч:

1. хадгалуулагчийн мөнгөн хөрөнгөнөөс зөвхөн түүний зөвшөөрөл буюу даалгавраар гүйлгээ хийх;
2. гэрээнд заасан нөхцөлийн дагуу хадгалуулагчийн тавьсан анхны шаардлагаар түүний хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүү төлөх;

3. мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг үнэн зөв бодож, олгох;
4. хуульд зааснаас бусад тохиолдолд хадгалуулагчийн дансны нууцыг хадгалах;
5. өөрийн буруугаас учруулсан хохирлыг нөхөн төлөх зэрэг болно.

Банкны зээл

Иргэний хуульд зээл нь бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэгт хамаардаг. Харин хууль тогтоогч банк, эрх бүхий этгээдээс олгох зээлийг ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх гэрээний төрөлд хамааруулан өөрөөр зохицуулсан байна.

Банк тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэж төлөгдөх барьцаа, эсхүл батлан даалттайгаар өөрийн болон түүнд хадгалуулсан бусдын мөнгөн хөрөнгийн зохих хэсгийг өөрийн нэрийн өмнөөс бусад этгээдэд олгохыг зээл гэнэ.

Банкны зээл нь:

Зориулалттай	Давтамжтай	Барьцаатай
татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг зээлдүүлэхдээ тодорхой зориулалтаар олгоно.	банк санхүүгийн зуучлагчийн хувьд зээлийн байнгын давтамжтай олгодог.	банкны зээл үүргийн гүйцэтгэлийг хангах аргаар заавал хангагдсан байна.

Банкны нийтэд зарласан зээлийн зориулалт, хүү, хугацаа болон бусад нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн зээлдэгчтэй банк харилцан тохиролцож байгуулсан зээлийн гэрээний үндсэн дээр зээл олгоно. Банкны зээлийн гэрээ нь бодит шинжтэй. Учир нь талууд зээлийн гэрээнд гарын үсэг зурах нь зээл олгох зөвшөөрөл юм. Банк зээлдэгчийн дансанд гүйлгээ хийснээр зээлийн хүү бодогдоно.

Зээлийн гэрээнд талуудын оршин байгаа газрын хаяг, зээлийн дансны дугаар, зориулалт, зээлдэх мөнгөний дүн, хугацаа, зээлийн хүүгийн хэмжээ, уг гэрээний үүргийн биелэлтийг хангах арга хэлбэр, гэрээг өөрчлөх, цуцлах зэрэг гол нөхцөлүүд тусгагддаг.

Зээлийн хүү гэдэг нь тухайн мөнгөн хөрөнгийг ашигласны үнэ юм. Зээлийн гэрээний хугацаа дуусгавар болсон нь зээлдэгч зээл, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Банк зээлийн үндсэн нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн этгээдийн хүсэлтийг хүлээн авч зээлийн судалгааны ажлыг эхлүүлэх үеэс эхлэн зээлийг төлж дуустал зээлдэгч бүр дээр зээлийн хувийн хэрэг хөтөлнө. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо зээлийн үйл ажиллагааны тухай хуульд заасан бүрдүүлбэрийн дагуу тооцоо, судалгаа, мэдээ, мэдээлэл зэрэг бусад баримт бичгийг зээлийн хувийн хэрэг гэдэг. Зээлийн хувийн хэрэг нь архивын ач холбогдолтой, мөн Монголбанкны хяналт, шалгалтын объект болдог юм.



Барьцаалбар

Банк, болон эрх бүхий этгээдээс олгох зээл нь үүргийн гүйцэтгэлийг хангах аргаар заавал хангагдсан байх ёстой. Иргэн, хуулийн этгээд байгуулсан зээлийн гэрээний үүргийг баталгаажуулж үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ байгуулсан тохиолдолд 2009 оны 7 дугаар сарын 09-ний өдөр УИХ-аас баталсан Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан журмаар барьцаалбар үйлдэнэ.


Хууль ёсны эзэмшигчийн үл хөдлөх эд хөрөнгийн барьцаагаар хангагдсан мөнгөн төлбөрийн үүргийн биелэлтийг хүлээн авах, шаардах эрх болон үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрхийг гэрчилсэн зөвшөөрлийн, биет үнэт цаасыг барьцаалбар гэнэ.

Барьцаалбарт барьцаалуулагчийн албан ёсны нэр, хяаг, барьцааны эрх үүсэх үндэслэл, барьцаагаар хангагдах үүргийн хэмжээ, барьцаагаар хангагдах үүргийг хугацаанаас өмнө гүйцэтгэж болох эсэх, барьцааны зүйлийн нэр, түүний шинж байдлын тодорхойлолт, байршил, эрхийн улсын бүртгэлийн дугаар, гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байгаа эсэх тухай заалт, барьцаалбарыг түүний хууль ёсны эзэмшигч бусдад шилжүүлэхийг барьцаалуулагч зөвшөөрсөн эсэх, барьцааны зүйлээс шаардлагыг хангах журам, барьцаалбар үйлдсэн он, сар, өдөр зэргийг агуулна.

Барьцаалуулагч нь барьцаалбарыг улсын бүртгэлийн байгууллагаас баталсан загварын дагуу нэг хувь үйлдэн, барьцааны гэрээний хамт улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас


Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь хуульд заасан хөрөнгөөр баталгааждаг, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжинд төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас байна.



Баталгаат үнэт цаас гаргагч нь хуульд заасан журмын дагуу байгуулагдсан, Санхүүгийн зохицуулах хорооноос хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй хязгаарлагдмал хариуцлагатай тусгай зориулалтын компани байна. Барьцаат үнэт цаасыг банк, орон сууцны санхүүжилтийн компани гаргах эрхтэй. Барьцаат үнэт цаас гаргагч нь өөрийн эзэмшилд байгаа санхүүгийн тайлан, тэнцэлд тусгагдсан хөрөнгө болон түүнийг хангах арга, хөрөнгөөс олох орлогыг барьцаалах бөгөөд уг барьцааны хөрөнгийг өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд тусгаарлан уг хөрөнгийн эргэн төлөлтөөр үнэт цаасны төлбөрийг тэргүүн ээлжинд төлнө.

Төлбөр тооцоо

Иргэн хуулийн этгээд хоорондын гүйцэтгэсэн ажил үйлчилгээ, нийлүүлсэн бараа бүтээгдэхүүнтэй холбоотой тэдний хооронд төлбөр тооцооны харилцаа үүсдэг.





Иргэн, хуулийн этгээд хуульд тусгайлан заасан баримт материалыг бүрдүүлэн тогтоосон журмын дагуу банкинд данс нээлгэж төлбөр тооцооны үүрэг гүйцэтгүүлэх боломжтой.

Үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгтээр хийх гүйлгээг бэлэн, төлбөр тооцооны баримтаар хийх гүйлгээг бэлэн бус гэсэн төлбөр тооцооны 2 хэлбэр байдаг. Бэлэн мөнгөний төлбөр тооцоо банкаар дамжуулан гүйцэтгэх ажиллагаа нь талууд харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр явагдана. Бэлэн бус мөнгөний төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, чек, вексель, төлбөрийн карт болон бусад төлбөр тооцооны баримтаар гүйцэтгэнэ.

Банкны төлбөр тооцооны харилцаанд төлбөр хүлээн авагч, төлбөр хариуцагч оролцдог. Банк энэ харилцаанд төлбөр гүйцэтгэж оролцохдоо төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэр буюу баримтыг бичсэн он, сар, өдөр, төлбөр хүлээн авагч, төлбөр хариуцагчийн дансны дугаар, нэр, үйлчлэгч банкны нэр, гүйлгээний утга, мөнгөний дүнг тоо болон үсгээр бичиж, баталгаатай гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсныг нягтлана.

Төлбөрийн баталгаа гаргах

Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу банк өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах үйл ажиллагааг эрхлэнэ. Үүрэг гүйцэтгэгч нь ямар нэгэн үйлдэл хийх, эсхүл тодорхой үйлдэл хийхээс татгалзах үүргийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх бөгөөд үүрэг гүйцэтгүүлэгч нь түүнээс уг үүргээ гүйцэтгэхийг шаардах нь үүргийн эрх зүйн харилцаа юм.

Баталгааний гэрээгээр банк үүрэг гүйцэтгүүлэгчийн бичгээр тавьсан шаардлагаар үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс мөнгөн төлбөрийг гүйцэтгэх, үүрэг гүйцэтгэгч баталгаа гаргагч банкинд төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ.

Төлбөрийн баталгаа гаргагч - үүрэг гүйцэтгэгчийн өргөдлийг үндэслэн үүрэг гүйцэтгэгчтэй төлбөрийн баталгааны гэрээ байгуулж байгаа банк .



Үүрэг гүйцэтгүүлэгч - үүрэг хүлээгчээс гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж, төлбөр тооцоо гүйцэтгэхийг шаардах эрх бүхий этгээд.



Үүрэг гүйцэтгэгч - төлбөрийн баталгааны гэрээний дагуу банкны хүлээсэн үүрэг, гүйцэтгэсэн төлбөрийг тодорхой хугацааны дараа буцаан төлж барагдуулах иргэн, хуулийн этгээд.

Банкны үйл ажиллагааны онцлогоос хамаарч гүйцэтгэлийн, урьдчилгаа төлбөрийн, гэрээний төлбөрийн баталгаа гэсэн төрлүүд байна. Банкны төлбөрийн баталгаа хугацаатай байх ба үндсэн үүргийн гүйцэтгэлийн хангагдах хугацаагаар тодорхойлогдоно.

Санхүүгийн түрээс

Банкны тухай хуулийн 6.1.10-т заасны дагуу санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монголбанкнаас авна.

Санхүүгийн түрээс нь түрээслүүлэгч нь түрээслэгчийн захиалсан буюу сонгосон эд хөрөнгийг нийлүүлэгчээс өөрийн нэр дээр худалдан авч түрээслэгчийн ашиглалтад шилжүүлэх үйл ажиллагаа юм.

Түрээслүүлэгч - Монголбанкнаас санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан банк.

Түрээслэгч - үл хөдлөх эд хөрөнгө болон хөдлөх хөрөнгийг түрээслүүлэгчээс өөрийн эзэмшилд шилжүүлэн авах зорилгоор тогтмол хугацаанд түрээсийн төлбөр төлөх үүргийг хүлээсэн иргэн, хуулийн этгээд.

Нийлүүлэгч - түрээслэгчийн захиалгаар гэрээний зүйл болох эд хөрөнгийг үйлдвэрлэх буюу нийлүүлэх, түрээслүүлэгчээс зохих хөлс, зардлыг шаардах эрх бүхий хуулийн этгээд.

Санхүүгийн түрээсийн гэрээг бичгээр хийнэ. Санхүүгийн түрээсийн гэрээний гол нөхцөлөөр гэрээний зүйл болох эд хөрөнгийн нийт үнэ, түрээсийн төлбөр, санхүүгийн түрээсийн хүү, түүнийг төлөх хугацаа, түрээсийн гэрээ дуусгавар болоход эд хөрөнгийн өмчлөх эрх зэрэг болно.

Итгэлцэл

Санхүүгийн зохицуулах хороо Монголбанкны саналыг бичгээр авсны үндсэн дээр банк, түүний хараат болон охин компанид итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож байна.

Итгэлцэл гэж итгэмжлэгчийн бэлэн мөнгө, зээл бусад активыг үнэгүүдлээс хамгаалж, ашиг (үр шим) олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцож байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр итгэмжлэгдэгчээс гэрээнд заасан хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг хэлнэ.



Өөрөөр хэлбэл, тусгай зөвшөөрөлтэй банк, түүний хараат болон охин компанид итгэлцлийн үйлчилгээний дагуу мөнгөн хөрөнгөө байршуулж, тодорхой хугацааны дараа хүү тооцуулж авна гэж ойлгоно.

Итгэмжлэгдсэн өмчлөгч буюу банк гуравдагч этгээдтэй харилцаанд орохдоо өөрийн нэрийн өмнөөс өмчлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж, үр дагаврыг нь хариуцах бөгөөд итгэмжлэгчийн ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулсны улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Даатгалын зуучлал

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан банк, түүний хараат болон охин компанид Монголбанкны зөвшөөрсөн саналын үндсэн дээр Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрлийг олгож болно.

Даатгалын зуучлал нь даатгагч болон даатгуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, үүнийхээ төлөө хөлс, шагнал авах үйл ажиллагаа юм. Даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэхэд Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д тусгасан ерөнхий шаардлагаас гадна даатгалын зуучлалын үйл ажиллагааг хариуцах тусгай нэгжтэй байх, нэгжийн удирдлага, албан хаагчид даатгалын сургалтад хамруулсан байх шаардлагыг тавьдаг байна. Нэгжийн удирдлага нь Санхүүгийн зохицуулах хороонд даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ тайланг цаг тухайд нь өгөх, даатгалын зуучлалын өдөр тутмын үйл ажиллагааг удидах, зохион байгуулах чиг үүрэгтэй.

Банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэхэд 2-оос доошгүй даатгалын компанитай хамтран ажиллах гэрээ байгуулах ёстой. Даатгалын зуучлалын үйл ажиллагааг банк, түүний салбараар дамжуулж байгаа учраас энэхүү гэрээнд даатгалын хураамжийн орлогыг даатгагчийн дансанд төвлөрүүлэх, мөн даатгалын тохиолдол үүсэхэд даатгалын хураамжийн орлогыг төвлөрүүлсэн эсэхээс үл хамааран даатгагч даатгуулагчид нөхөн төлбөр олгох талаархи нөхцөлүүдийг тусгадаг.

Андеррайтерын үйлчилгээ

Андеррайтер гэдэг нь шинээр хувьцаа гаргаж буй аж ахуйн нэгжийн нийтэд санал болгож буй хувьцааны танилцуулга бэлтгэх, анхдагч зах зээл дээр борлуулах, худалдах, худалдан авах зэрэг үйл ажиллагааг ойлгоно. Олон улсын практикт андеррайтерууд нь ихэвчлэн хөрөнгө оруулалтын банкууд байдаг. Банк, түүний охин болон хараат компани нь Монголбанк татгалзахгүй гэж бичгээр мэдэгдсэн

тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос андеррайтерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авч болно.

Кастодиан

Манай улсад зөвхөн банк, түүний хараат болон охин компанид Монголбанк татгалзахгүй гэдгээ бичгээр мэдэгдсэн тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороо кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож болдог. Кастодианы үйл ажиллагаа нь харилцагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр дараахь үйлчилгээ үзүүлэхийг ойлгоно. Үүнд:

- Үнэт цаастай холбоотой орлого (үнэт цаас борлуулсны орлого, ногдол ашиг, хүү)-ыг кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд хүлээн авах, харилцагчийн дансанд байршуулах, харилцагчид олгох, шилжүүлэх;
- Харилцагчийн итгэмжлэл, түүний зааврын дагуу хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал өгөх;
- Татвартай холбоотой үйлчилгээг харилцагчдад үзүүлэх;
- Үнэт цаас ба үнэт цаас гаргагчтай холбоотой болон харилцагчтай байгуулсан гэрээнд заасан бусад мэдээллийг цуглуулж харилцагчид мэдээлэх;
- Харилцагчийн хийсэн үнэт цаасны арилжаатай холбоотой төлбөр тооцоог гүйцэтгэх зэрэг болно.

Кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээнд кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд болон харилцагчийн хүлээх үүрэг, эдлэх эрх, үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамжийн хэмжээ, гэрээ цуцлах журам, харилцагчийг мэдээллээр хангах, харилцагчийн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, үнэт цаас ба мөнгөн хөрөнгийн тулгалт хийх болон давагдашгүй хүчин зүйлсийн нөхцөл, хууль тогтоомжоор хориглоогүй бусад нөхцлийг тусгасан байдаг.

Факторинг

Банк, түүний хараат болон охин компани Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр факторингийн үйлчилгээ үзүүлнэ. Факторинг нь авлагыг баталсан тооцооны баримт бичигт үндэслэн богино хугацаанд түргэн хөрвөх чадвартай мөнгө болгох үйл ажиллагаа (авлагыг хямдруулан худалдан авагч, авлагыг эзэлдүүлэгчдэд цуглуулж өгөгч, авлагыг барьцаалан зээл олгох)-г хэлэх буюу эзэлдүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийн шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах (шилжүүлэх), энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцах үйл ажиллагаа юм.

Банкны систем дэхь зээлийн чанарыг дээшлүүлэх, өрийн сүлжээг арилгах замаар эдийн засгийг эрүүлжүүлэхэд факторингийн үйлчилгээ тустай. Банк, түүний охин болон хараат компани факторингийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:



- **хяналттай байх:** зээлдэгчийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд тогтмол хяналт хийж, бодлого боловсруулан ажиллах замаар хяналт тавьж байх,
- **хугацаатай байх:** худалдан авсан авлагыг төлөх үйл ажиллагааг тодорхой хугацаанд хэрэгжүүлэх,
- **эргэн төлөгдөх:** авлагатай холбогдон гарсан санхүүжилт, зээл эргэн төлөгдөж байх.
- **төлбөртэй байх:** факторингийн үйлчилгээний төлөө үйлчлүүлэгч урамшуулал, шимтгэл төлж байх зэрэг болно.

Факторингийн үйлчилгээний зөвшөөрлийг олгохдоо ямар хүрээнд харилцагч, үйлчлүүлэгчийг хэрхэн хамруулах, хаанаас олох, үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар бизнес төлөвлөгөө боловсруулж, өр авлагыг богино хугацаанд цуглуулж, барагдуулах учраас хууль зүйн мэдлэг чадвартай, харилцааны соёл, сэтгэл зүйн сайн бэлтгэлтэй боловсон хүчинтэй байхыг шаардана.

Хоёр. Семинар 1

Бодлого:

Иргэн “Г” “ХХХ” банктэй эрх зүйн тэгш орчинд харилцан тохиролцож зөвшөөрсний үндсэн дээр доорхи нөхцөлтэйгээр зээлийн гэрээ байгуулжээ. Зээлдэгчийн төлөх үндсэн зээл, хүүгийн төлбөр төлөх графикыг гэрээний хавсралтаар баталж, зээлдэгч өөрийн өмчлөлийн орон сууцыг барьцаалсан байна.

Данс	Олгосон		Төлөх	Зориулалт
Зээлийн хэмжээ	15 000 000 төгрөг (Арван таван сая төгрөг)	Он	2010	2012	Орон сууцны засвар
		Сар	09	02	
Хэлбэр	Бэлнээр	Өдөр	15	15	
Сарын хүү	2,0%	Зээлийн хугацаа		18 сар	
Зээлдэгч зээлийн хүүг сар бүрийн 25-ны дотор төлнө.					

Өгөгдөл:

Талуудын байгуулсан зээлийн гэрээний зарим заалтаас:

- “.....Графикийн дагуу үндсэн зээл ба зээлийн хүүг төлөөгүй нөхцөл нь гэрээний ноцтой зөрчилд тооцно.
-Зээлдэгч зээл, хүүгийн төлбөрийг хугацаандаа төлж барагдуулаагүй бол Иргэний хуулийн 222.5 болон 452.2-т заасны дагуу хэтрүүлсэн хугацаанд зээлийн хүүг үргэлжүүлэн төлөхөөс гадна, үндсэн хүүгийн 20%-тай тэнцэх

хэмжээний нэмэгдүүлсэн хүүг үүргийн гүйцэтгэл бүрэн хангагдаж дуусах хүртэл төлөхөөр талууд тохиролцов. (Зээлдэгч гэрээнд заасан хугацаандаа авсан зээлээ төлөөгүй тохиолдолд нэмэгдүүлсэн хүүг тооцох бөгөөд хугацаандаа төлөөгүй зээлийн үндсэн өрийн үлдэгдлээс бодогдох хүүнээс нэмэгдүүлсэн хүүг тооцно).

-Төлбөрийг нэмэгдүүлсэн хүү, үндсэн хүү, зээл гэсэн дарааллаар төлнө.
-Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд зээлдэгчийн бизнесийн нэр хүндэд банк халдах эрхтэй.
-Зээлдэгч зээл төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд зээлдэгчийн зээлээ төлөөгүй талаарх мэдээллийг гэрэл зураг болон зээл төлөх шаардлагын хамт хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг зээлдэгч өөрөө зөвшөөрсөн болно” гэжээ.

Шийдвэрлэх асуудал:

1. Банкны зээлийн гэрээний гол нөхцөлийн талаар ярилцаж, тодорхойлно уу?
2. Энэхүү гэрээнд туссан байгаа дээрх заалтуудын агуулгад хууль зүйн дүгнэлт хийнэ үү.
3. Эдгээр заалтуудтай холбоотой Иргэний хууль болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн холбогдох зохицуулалтыг судлан үзэж өөрсдийн дүгнэлтийг бичих.

Семинар 2

Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр банкны эрхэлдэг итгэлцэл, даатгалын зуучлал, андеррайтер, кастодиан, факторинг гэсэн 5 үйл ажиллагааны талаар бид авч үзсэн.

Шийдвэрлэх асуудал:

Дээрхи 5 үйл ажиллагаа бүрийн онцлог, ач холбогдол, Санхүүгийн зохицуулах хорооноос олгох тусгай зөвшөөрлийн эрх зүйн зохицуулалтын /тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл олгох журам, бүрдүүлэх баримт материал, тусгай зөвшөөрөл олгохоос татагалзах үндэслэл, хүүчингүй болгох үндэслэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тавих хяналт, хүлээлгэх хариуцлагын талаар холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг судлан үзэж танилцуулга бэлдэх,

Хяналтын асуулт:

1. Банкны хараат болон охин компанийг тодорхойлно уу?
2. Банкны хууль тогтоомжид эрхлэх үйл ажиллагаатай холбоотой ямар хориглолт, хязгаарлалт байдаг вэ?



3. Зээлийн хувийн хэрэг ямар бүрдүүлбэртэй вэ? Хувийн хэргийн ач холбогдлыг тайлбарлана уу?
4. Банк ямар төрлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах эрхтэй вэ?
5. Барьцаалбарын ач холбогдлыг тодорхойлно уу.

СЭДЭВ 4. БАНКНЫ ТӨРӨЛ, САНХҮҮГИЙН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУД

Сэдвийн зорилго: Банкны төрөл тэдгээрийн үйл ажиллагааны нийтлэг буюу онцлогийн талаар онолын мэдлэг олгож, олон улсын байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар ойлголт өгнө.

Түлхүүр үг: Хөрөнгө оруулалтын банк, Хөгжлийн банк, Дэлхийн банк (WB), Шинэчлэл хөгжлийн олон улсын банк, Олон улсын хөгжлийн ассоциаци, Олон улсын санхүүгийн корпораци, Хөрөнгө оруулалтын баталгаа олгох олон талт агентлаг, Хөрөнгө оруулалтын хэлцлийн олон улсын төв, Азийн хөгжлийн банк (ADB), Олон улсын валютын сан (IMF), Хяналт шалгалтын Базелийн хороо.

Нэг. Тойм лекц:

Арилжааны банк

Банкны тухай хуулийн 3.1.1-т “банк” гэж хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээдийг хэлнэ” гэж тусгажээ. Арилжааны банк нь хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг өсгөх зорилготой ашгийн төлөө, бусдын хөрөнгөөр үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллага юм. Тэдний ашиг олох гол үйл ажиллагаа нь зээлийн бүтээгдэхүүн бөгөөд орлогын дийлэнх хэсгийг зээлийн хүүгийн орлого эзэлдэг.



Монголын арилжааны банкууд нь нийтлэг үйл ажиллагаатай бөгөөд Банкны тухай хуулийн 6.1-д заасан үйл ажиллагааг Төв банкны, 6.2-т заасан үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэйгээр тус тус явуулна.

Хөрөнгө оруулалтын банк

Хөрөнгө оруулалтын банк нь хөрөнгийн зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагааг голчлон хийхээс гадна санхүүгийн зөвлөх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг санхүүгийн байгууллага юм. Хөрөнгө оруулалтын банк нь хөрөнгийн зах зээлийн гол тоглогч болохоос гадна санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалтын оновчтой багц бүрдүүлэлтэд чухал үүрэг гүйцэтгэж байдаг.

Хөгжлийн банк

Хөгжлийн банк нь Монгол улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилго бүхий Монгол улсын хөгжлийн банкны тухай хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх, тусгайлсан чиг үүрэгтэй ашгийн төлөө төрийн өмчит хуулийн этгээд юм.

Дэлхийн банк (WB)

Дэлхийн Банк нь өөрийн гишүүн хөгжиж буй орнуудад ядуурлыг бууруулах зорилгоор зээл олгодог банк юм. Дэлхийн Банк нь анх “Сэргээн Босголт, Хөгжлийн Олон Улсын Банк” нэртэйгээр 1944 онд үүсгэн байгуулагдсан. Анх үйл ажиллагаагаа Дэлхийн II дайны дараах сэргээн босголтын ажлыг түргэвчлэх зорилготой эхлүүлж байжээ. Гишүүн улсуудын тоо нэмэгдэж тэдний хэрэгцээ өөрчлөгдөхийн хирээр Дэлхийн Банк өргөжин тэлсээр одоогийн байдлаар таван агентлагаас бүрдэж байна. Дэлхийн банкны бүрэлдэхүүнд Шинэчлэл хөгжлийн олон улсын банк, Олон улсын хөгжлийн ассоциаци, Олон улсын санхүүгийн корпораци, Хөрөнгө оруулалтын баталгаа олгох олон талт агентлаг, Хөрөнгө оруулалтын хэлцлийн олон улсын төв зэрэг байгууллагууд багтдаг байна.

Азийн хөгжлийн банк (ADB)

Азийн хөгжлийн банк нь анх 1966 онд Олон улсын хөгжлийг хангах санхүүгийн институт хэлбэрээр үүссэн. Ази, Номхон далайн бүс нутагт эдийн засгийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхүйц санхүү, техникийн нөхцөл бололцоогоор хангаснаар эдийн засгийн хөгжлийг хурдсгах үүрэгтэй ажилладаг байна. Нийгмийн болон хувийн салбарт ядуурлыг бууруулах чиглэлээр техник, технологи, хөдөө аж ахуй, ашигт малтмал, эрчим хүч, санхүү эдийн засаг, хүнд үйлдвэр болон шатахуунаас бусад төрлийн ашигт малтмалууд, тээвэр харилцаа холбоо, дэд бүтцийн салбар, боловсролын зэрэг салбаруудад төслийн зээлийг олгодог бөгөөд АХБ-аас олгогдож буй зээлийн 40 орчим хувь нь ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд зориулагддаг байна.



Олон улсын валютын сан (IMF)

ОУВС нь валютын зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилготойгоор дайны дараах сэргээн босголтын нэг алхам болж Олон Улсын Сэргээн босголт Хөгжлийн Банктай (International Bank for Reconstruction and Development) хамт 1946 оны 3 дугаар сард, 21 улсын бүрэлдэхүүнтэй үүсгэн байгуулагджээ. 1947 онд ОУВС нь үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд НҮБ-тай хамтран ажиллах гэрээний дагуу НҮБ-ын харьяа мэргэжлийн байгууллага болсон байна. Дэлхийн банктай хамтран олон улсын мөнгөний бодлогын горим, ерөнхий дүрмийг тогтоодог. 2012 оны байдлаар 187 орон гишүүнчлэлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хяналт шалгалтын Базелийн хороо (BASEL committee on supervisions)

Швейцарийн Базел хотноо анх 1974 онд байгуулагдсан хяналт шалгалтын Базелийн хороо нь гишүүн орнуудын төв банкуудын төлөөлөгчид хоорондоо мэдээлэл солилцох, олон улсын түвшинд банкны бизнесийн удирдлагын чадавхийг сайжруулах, шаардлагатай тохиолдолд хяналтын хэмжүүрүүдийг тогтоож өгснөөр дэлхийн хэмжээний банкны салбарын удирдлага, дүрэм журмын зааг ялгааг багасгах зорилготой олон улсын байгууллага юм. Базелийн хороо нь ямар нэг улсын хууль эрхзүйн орчинд захирагддаггүй боловч хорооноос гарч байгаа шийдвэрүүд нь энгийн, ерөнхий хэдий ч гишүүн орны болон олон улсын банкны салбарт зайлшгүй шаардлагатай стандарт болдог ороо онцлог юм.

Хоёр. Нэмэлт даалгавар

Олон улсын санхүүгийн байгууллагуудаас нэгийг сонгон авч "Байгууллагын үүсгэн байгуулагдсан учир шалтгаан, тэдгээрийн үйл ажиллагаа, түүхэн замнал болон банкны салбарт үзүүлэх нөлөөлөл" сэдвээр бие даалтын ажил гүйцэтгэх.

Хяналтын асуулт:

1. Арилжааны банк хөрөнгө оруулалтын банкны үүргийг гүйцэтгэж болох уу? Ямар эрх зүйн актаар зохицуулах вэ?
2. Хөгжлийн банкны онцлогийг тодорхойлно уу? Хөгжлийн банк байгуулах шаардлага нь юу вэ?
3. Хөрөнгө оруулалтын банк эх үүсвэрээ хэрхэн бүрдүүлдэг вэ?
4. Олон улсын санхүүгийн байгууллагуудын үндсэн чиг, үүргийг тайлбарлана уу.

III БҮЛЭГ. БАНКНЫ ХӨРӨНГӨ

Бүлгийн зорилго: Банкны нягтлан бодох бүртгэлийн онцлог, ажил гүйлгээг баримтжуулан бүртгэх үйл явц, санхүүгийн тайлан бэлтгэх процедурыг тайлбарлан таниулах, банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, банкны актив, пассивын

бүтэц, түүний оновчтой удирдлага, болзошгүй эрсдэлийн сангийн бүрдүүлэлт, түүний аргачлалын талаар онолын суурь мэдлэг олгоход оршино. .

СЭДЭВ 5. БАНКНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сэдвийн зорилго: Банкны тайлан тэнцэл, тэдгээрийн мөн чанар, өөрийн хөрөнгийн гүйцэтгэх үүрэг, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийг хэрхэн тооцох аргачлал, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэлийн талаар онолын суурь мэдлэг олгоно.

Түлхүүр үг: Банкны тайлан тэнцэл, өөрийн хөрөнгө, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.

Нэг. Тойм лекц:

Банкны тайлан тэнцлийн бүрэлдэхүүн хэсгүүд, тэдгээрийг тэнцэлд тусгах тухай

Банкууд дотооддоо нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (цаашид НББОУС гэх) болон Монгол улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудад бүрэн нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж мөрдөх шаардлагатай. Банк нь нягтлан бодох бүртгэлээ аккрузл¹ сууриар хөтөлж, ажил гүйлгээг дансны давхар бичилт²-ийн аргаар бүртгэнэ. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгж нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлэгдсэн байна.

Банкны удирдлага нь нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан бусад мэдээ баримтыг үнэн зөв гаргаж энэ талаар холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ. Банк нь дотооддоо өөрийн үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгасан, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг НББОУС-ын дагуу хөтлөх боломж бүхий дансны дугаар болон нэрээс бүрдсэн дансны дэлгэрэнгүй жагсаалтыг баталж, мөрдөх шаардлагатай.

Банкны дансны жагсаалт нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

1. Дансны төрөл

Данс нь дараах үндсэн төрөлд хуваагдана. Үүнд:

А. Балансын данс

Б. Орлого үр дүнгийн данс

1 Нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурь гэдэг нь мөнгө хүлээн авсан эсвэл төлсөн эсэхээс хамааралгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх арга юм.

2 Хийгдсэн ажил гүйлгээг холбогдох дансдын дебит, кредитэд зэрэг бичилт хийхийг дансны давхар бичилт гэнэ.



В. Балансын гадуурхи данс

А. Балансын данс нь:

1/ Хөрөнгийн данс

2/ Өр төлбөрийн данс

3/ Эзэмшигчдийн данс

Б. Орлого, үр дүнгийн данснь:

1/ Орлогын данс

2/ Зардлын данс

2. Дансны бүлэг

Балансын дансдыг хөрөнгө, өр төлбөрийн хөрвөх чадварын³ дарааллаар, орлого үр дүнгийн дансдыг үйл ажиллагааны төрлөөр дараах байдлаар бүлэглэнэ.

Хөрөнгө	Өр төлбөр
Мөнгөн хөрөнгө	Харилцах
Богино хугацаат хөрөнгө оруулалт	Хадгаламж
Зээл	Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	Бусад эх үүсвэр
Бусад хөрөнгө	Бусад өр төлбөр
Үндсэн хөрөнгө	Эзэмшигчдийн өмч
Биет бус хөрөнгө	
Урт хугацаат хөрөнгө оруулалт	

Орлого	Зардал
Үндсэн үйл ажиллагааны	Үндсэн үйл ажиллагааны
-Хүүний орлого	-Хүүний зардал
-Үйл ажиллагааны бусад орлого	-Үйл ажиллагааны бусад зардал
Үйл ажиллагааны бус орлого	Үйл ажиллагааны бус зардал
Онцгой шинжтэй орлого	Онцгой шинжтэй зардал
	Ашгийн татварын зардал

Банкны өнгөрсөн үйл ажиллагаа болон үйлдлийн үр дүнд үүсч бий болсон түүний мэдэлд байгаа ирээдүйд эдийн засгийн үр ашиг авч ирэх эдийн засгийн нөөц буюу чадавхийг хөрөнгө гэнэ.

Хөрөнгө нь гурван үндсэн чанарыг агуулна. Үүнд:

³ Хөрвөх чадвар гэдэг нь богино хугацаанд бэлэн мөнгө болон солигдох чадварыг хэлэх бөгөөд банкны балансын актив тал нь хөрвөх чадварын эрэмбээр дараалан бичигдэнэ.

- тэдгээр нь дангаараа буюу бусад хөрөнгөтэй хослон, шууд ба шууд бус замаар цэвэр мөнгөн гүйлгээ буюу үйлчилгээг нэмэгдүүлэх чадавхи бүхий ирээдүйн үр ашгийг агуулж байгаа;
- банк хөрөнгөөс олох үр ашигт хяналт тавьж чадахуйц байх;
- банк олсон үр ашгаа хянах буюу захирах эрх мэдлийг нэмэгдүүлэх ажил гүйлгээ буюу үйлдэл зэрэг болно.

3. Хөрөнгийн төрөл

- Мөнгөн хөрөнгө
- Богино хугацаат хөрөнгө оруулалт
- Зээл
- Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
- Бусад хөрөнгө
- Үндсэн хөрөнгө
- Биет бус хөрөнгө
- Урт хугацаат хөрөнгө оруулалт

Банкны өөрийн хөрөнгийн бүрдүүлэлт, тэдгээрийн үүрэг, нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээ



Эзэмшигчдийн өмч буюу капитал нь оруулсан капитал болон олсон капиталын нийлбэр. Эзэмшигчдийн өмч нь банкны нийт хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хассан дүнтэй тэнцүү байна.

Оруулсан капитал нь аливаа хугацаанд хувьцаанд төлсөн буюу өөр ямар нэг байдлаар бизнест ашиглахын тулд хувьцаа эзэмшигчдийн банкинд оруулсан хөрөнгийн нийт дүн. Оруулсан капиталд эргэлтэд байгаа өмчийн хувьцааны нэрлэсэн үнэ, гаргалтын аливаа хөнгөлөлтийг хассан цэвэр урамшуулал, захиалгын гэрээгээр төлсөн дүн зэрэг зүйлс багтана.



Олсон капитал нь банк ашигтай үйл ажиллагаа явуулсны үр дүнд нэмэгдсэн капитал. Энэ нь тухайн банкны хуваарилагдаагүй нийт орлого юм.

Хувьцаа нь банкинд хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн, санал өгөх, ногдол ашиг авах, банкыг татан буулгахад түүний эд хөрөнгөөс тодорхой хэсгийн өмчлөх эрхийг гэрчилж буй үнэт цаас.

Хувьцаат капитал нь худалдагдсан хувьцааны нэрлэсэн үнийн дүн.

Нэмж төлөгдсөн капитал нь хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн хэмжээг хэлнэ. Хувьцааг нэрлэсэн үнээс доогуур үнээр борлуулбал хүлээсэн алдагдлыг нэмж төлөгдсөн капиталын дансанд сөрөг тэмдэгтэйгээр харуулна.

Хуримтлагдсан ашиг нь үйл ажиллагаа эхэлсэн үеэс нэмэгдсэн капитал юм. Энэ нь тухайн тайлангийн хугацаанд олсон цэвэр ашгийн хэмжээгээр нэмэгдэж, алдагдлын хэмжээгээр буурна.

Хоёр. Семинар

Бодлого 1.

“Д” банкны активууд дараах байдалтай байна.

Активууд	Дүн	Эрсдэлийн хувь
Бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	10.000.000	0%
ЗГ-ын богино хугацаат үнэт аас	30.000.000	20%
ЗГ-ын урт хугацаат үнэт цаас	30.000.000	50%
Зээлийн багц	60.000.000	100%
Балансын гадуурх аккредитивийн баталгаа	20.000.000	100%

Шийдвэрлэх асуудал:

1. “Д” банкны Эрсдэлээр жигнэгдсэн активын⁴ дүнг үзүүлэлт тус бүрээр тооцно уу.
2. Нийт активын 5,33% -ийг анхдагч капиталаар санхүүжүүлдэг гэвэл уг банк Олон улсын капиталын стандартыг хангаж чадаж байгаа эсэхийг тодорхойлно уу.

Бодлого 2.

“Е” банкны эрсдэлээр жигнэгдсэн активын хэмжээ нийт активын 75%-тай тэнцүү. Нийт актив нь 5.000.000.000 төгрөг. Нийт өр төлбөр нь нийт активын 80%-ийг

4 Эрсдэлээр жигнэсэн актив гэдэг нь тухайн актив хөрөнгө тус бүрийг эргэн төлөгдөхгүй байх магадлалаар нь жигнэсэн дүн бөгөөд эргэн төлөгдөхгүй байх магадлалыг зохицуулах байгууллагаас тогтоож, түүнд үндэслэн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа үзүүлэлтийг тооцдог

эзэлдэг бол “Е” банкны хувьд Олон улсын капиталын стандарт болон Монголбанкны шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлно уу.

Хяналтын асуулт:

1. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг эдийн засгийн агуулгаар нь тайлбарлана уу.
2. Банкны өөрийн хөрөнгийн гүйцэтгэх үүрэг юу вэ?
3. Банкны нягтлан бодох бүртгэлийн онцлог, давуу талыг тодорхойлно уу?

СЭДЭВ 6. БАНКНЫ АКТИВ, ПАССИВЫН УДИРДЛАГА

Сэдвийн зорилго: Банкны актив, пассивын бүтэц, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүд, актив, пассивын удирдлага, болзошгүй эрсдэлийн сангийн бүрдүүлэлт, түүний аргачлалын талаар онолын суурь мэдлэг олгоно.

Түлхүүр үг: Банкны актив, пассив, эрсдэлийн сан, гадаад төлбөр тооцоо, SWIFT.

Нэг. Тойм лекц:

Актив, пассивын удирдлагын үндсэн ойлголт

Банкны өнгөрсөн үйл ажиллагаа болон үйлдлийн үр дүнд үүсч бий болон түүний мэдэлд байгаа ирээдүйд эдийн засгийн үр ашиг авч ирэх эдийн засгийн нөөц буюу чадавхийг актив хөрөнгө⁵ гэнэ. Хөрөнгө нь гурван үндсэн чанарыг агуулна. Үүнд:

Хөрөнгө дангаараа буюу бусад хөрөнгөтэй хослон, шууд ба шууд бус замаар цэвэр мөнгөн гүйлгээ буюу үйлчилгээг нэмэгдүүлэх чадавхи бүхий ирээдүйн үр ашгийг агуулж байдаг;

Банк хөрөнгөөс олох үр ашигт хяналт тавьж чадахуйц байх;

Банк олсон үр ашгаа хянах буюу захирах эрх мэдлийг нэмэгдүүлэх ажил гүйлгээ буюу үйлдэл зэрэг болно.

⁵ Хөрөнгийн төрлүүдийг бүлэг 3-ын 6.1.3-аар хэсгээс дэлгэрүүлж харна уу.



Өр төлбөр гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болсон банкны бусдын өмнө хүлээх үүрэг бөгөөд үүргийн биелэлт нь (1) эдийн засгийн үр ашгийг агуулж буй нөөцийн гадагш урсгалаар барагдах; (2) бодитоор хэмжиж болохуйц байна. Өр төлбөр нь дараах үндсэн шинж чанартай. Үүнд:

Өнгөрсөн үйл явдлаас бий болсон одоогийн үүрэг хариуцлага оршин байх. Энэ нь өнгөрсөн хугацаан дахь ажил гүйлгээ эсвэл үйл явдлын үр дүнд гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг бий болгох бөгөөд хараахан барагдаагүй зүйл;

Тайлагнагч банкны хувьд санхүүгийн сөрөг үр дагавартай зүйл бөгөөд өөрөөр хэлбэл банк нь үүргээ биелүүлэхийн тулд нэмж өр төлбөр үүсгэх эсвэл нэг буюу хэд хэдэн байгууллагад мөнгө болон бусад хөрөнгөө шилжүүлэн өгөх шаардлагатай болдог;

Банк нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийг үр ашигтай хөрөнгө оруулалтын багцад байршуулж, түүнээсээ өгөөж хүртсэнээр төлбөрийн чадварыг хангаж, ашиг олох боломжтой болно. Өөрөөр хэлбэл, банкны удирдлага санхүүжилт, хөрөнгө оруулалтын оновчтой бодлого явуулснаар ашгийн төлөөх зорилгодоо хүрэх боломжтой болно. Тиймээс банкуудын хувьд санхүүжилт, хөрөнгө оруулалтын боломжит хувилбаруудыг хэдий чинээ өргөжүүлж чадна, төдий чинээ оновчтой хөрөнгө оруулалтын багцын сонголт хийх боломжууд нэмэгдэнэ.

Зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, түүний бүрдүүлэлт


Банк олгосон зээл, хөрөнгө оруулалтыг эргэн төлөгдөх хугацаа, чанар, эргэж төлөгдөх магадлалыг нь харгалзан ангилал замаар зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах эрсдэлийн санг тооцож, зардал хэлбэрээр нягтлан бодох бүртгэлд тусгана. Зээлдүүлэгч нь зээл, үнэт цаас, хүлээж болзошгүй үүрэг, бусад активыг дор дурдсан байдлаар ангилж, хугацааны болон чанарын үзүүлэлт өөрчлөгдөх тухай бүрт ангиллыг хийнэ.

Зээлдүүлэгч нь өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөөс активыг хугацааны болон чанарын үзүүлэлтээр үнэлж, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг зөвхөн хугацааны үзүүлэлтээр ангилна. Ингэхдээ хугацааны үзүүлэлтээр ангилсны дараа чанарын үнэлгээг хийж ангиллыг тодорхойлох шаардлагатай. Активын ангилалд эрсдэлийн санг актив тус бүрийн үлдэгдэл дүнгээс дор заасан хувь хэмжээгээр байгуулна. Үүнд:

№	Активын ангилал	Эрсдэлийн сан бүрдүүлэх хувь
	Хэвийн ангилалд	0 хувь
	Хугацаа хэтэрсэн ангилалд	5 хувь
	Чанаргүй ангилалтай актив, үүнээс:	
	- хэвийн бус ангилалд	25 хувь
	- эргэлзээтэй ангилалд	50 хувь
	- муу ангилалд	100 хувь

Гадаад төлбөр тооцооны үндсэн ойлголтууд- SWIFT-ийн сүлжээ, түүний ашиглалт

Банк өөрийн харилцагч, үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор тэдний экспорт, импортын худалдаа, арилжааны нөхцөл дэх төлбөр тооцоог хэвийн, тасралтгүй, найдвартай хийх боломжийг олгож, гадаад төлбөр тооцооны олон төрөл, хэлбэрийг харилцагчиддаа санал болгож байдаг. Үүнд:



Гадаад төлбөр тооцоо нь маш олон төрлийн эрсдэлийг өөртөө агуулж байдаг бөгөөд тэр бүх эрсдэлийг өөртөө хүлээж, харилцагч үйлчлүүлэгчийг эрсдэл багатайгаар төлбөрөө хийх боломжийг олгож байдаг.

SWIFT- Society for Worldwide Interbank Financial Telecommunication буюу Олон улсын санхүүгийн харилцаа холбооны компьютерийн сүлжээ юм. Дэлхий даяар өргөн тархсан банк хоорондын санхүүгийн харилцаа холбооны энэхүү хэрэгсэл нь 1960-аад оны сүүл 1970-аад оны эхэн үеэс банкаар хийгдэж буй гадаад төлбөр тооцоог нэгдсэн нэг стандартаар загварчлан, мэдээллийг түргэн шуурхай, алдаагүй, аюулгүй байдлыг дээд зэргээр ханган солилцох хэрэгцээ шаардлагын үндсэн дээр гарч ирсэн бөгөөд 1977 онд анх банкуудын гадаад төлбөр тооцооны төлбөрийн хэрэгслийн үүргийг гүйцэтгэх болжээ. Энэхүү сүлжээгээр дэлхийн бүх тивийн 100 гаруй улсын 3000-аад банкууд үйлчлүүлж байгаа бөгөөд банк хоорондын харилцаанд ашиглагдах баталгаажсан мэдэгдэл дамжуулах үйлчилгээний стандарт программ хангамжийн сүлжээг ашиглан гадаад гуйвуулгын үйлчилгээ үзүүлж байгаа билээ. SWIFT-р дамжуулах гуйвуулгын шинж чанар нь:



Найдвартай - гуйвуулгын талаарх мэдээлэлд гуйвуулагч банк, хүлээн авагч банкнаас бусад гуравдагч тал нэвтрэх боломжгүй

Түргэн шуурхай - гуйвуулга илгээгч банкны мэдээлэл нь 5 секундын дотор хүлээн авагч банкинд хүрнэ

Аюулгүй - SWIFT сүлжээний төвүүд дэлхийн хэд хэдэн улс орнуудад төвлөрсөн үйлчилгээний төвүүдтэй байдаг

Хоёр. Семинар

Ангийн оюутнууд 5 хэсэгт хуваагдан, дээр дурьдсан гадаад төлбөр тооцооны төлбөрийн аргуудаас нэгийг сонгон, тухайн аргатай холбоотой эрх зүйн ямар зохицуулалтууд үүсч болох талаар группийн хэлэлцүүлэг өрнүүлэх. Оролцогч талуудын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн ямар механизм үйлчлэх, түүнийг манай улсад ямар хууль, дүрэм, журам, актуудаар зохицуулдаг талаар ярилцана уу.

Хяналтын асуулт:

1. Банкны актив, пассивын удирдлагын зорилго, чиглэл юу вэ?
2. Зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан бүрдүүлэлтийн ач холбогдол юу вэ?
3. SWIFT-ийг гадаад төлбөр тооцоонд ашигласнаар банкинд ямар давуу болон сул тал, боломж болон эрсдэл учирч болох вэ?

IV БҮЛЭГ. ТӨВ БАНК БА ХАРИЛЦАГЧИЙН ЭРХ АШИГ

Бүлгийн зорилго: Төв банкны бүрэн эрх, хараат бус байдал, үйл ажиллагаа болоод банкны харилцагч, түүний эрх ашгийг хамгаалах, банк, банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт, харилцагчаа танин мэдэх, сэжигтэй харилцагчаас татгалзаж, мөнгө угаах гэмт хэргийн хохирогч болохоос сэргийлэх, банк, банк бус санхүүгийн байгууллагын дотоод аудит, банкны секторт ёс зүйн дүрмийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагын талаар цогц мэдлэг эзэмшинэ.

СЭДЭВ 7. ТӨВ БАНК, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сэдвийн зорилго: Төв банкны бүрэн эрх, хараат бус байдал, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын тухай системтэй мэдлэг эзэмшин, орчин үеийн банкны тогтолцооны талаарх ойлголт гүнзгийрнэ.

Түлхүүр үг: Төв банкны хараат бус байдал, чиг үүрэг, үйл ажиллагаа.

Нэг. Тойм лекц:

Хоёр шатлалт банкны тогтолцоо-Төв банкны үүсэл хөгжил, хараат бус байдал

1990 оноос манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих, өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрч хөгжүүлэх алхам хийж эхэлсэн нь улсын банкны ганц шатлал бүхий тогтолцоог халж, хоёр шатлал бүхий банкны шинэ тогтолцоо үүсч хөгжих⁶ нөхцөлийг бүрдүүлсэн. 1991 оны 4 дүгээр сарын 4-нд Улсын Бага Хурлаас Монгол улсын банкны тухай хуулийг баталснаар манай улсад 2 шатлал бүхий банкны тогтолцоо хөгжих эрх зүйн үндэс тавигдсан. Банкны тухай хуулийн 3-р зүйлд “Монгол улс дахь банкны тогтолцоо нь Монгол улсын төв банк, арилжааны банкнаас бүрдэнэ” гэж зааж байжээ.⁷ Банкны шинэ тогтолцооны гол цөм нь Төв банк байх эрх зүйн үндэс Банкны тухай шинэ хуульд “Монгол улсад мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий эмиссийн банкыг Монгол Улсын Төв банк гэнэ” хэмээн эрх зүйн байдлыг тодорхойлсон байдаг. Монголбанкны үйл ажиллагаанд хяналт тавьж байх, түүний дүрэм, жилийн эцсийн тайлан тэнцлийг батлах, ашгийн хуваарилалт, орлого зарлагын төсвийг батлах, Монголбанкны ерөнхийлөгчийг томилох зэрэг хууль зүйн зохицуулалтууд Улсын Их Хурлын эрх хэмжээнд байхаар Банкны хуульд тусгаж, Монголбанкыг Засгийн газраас шууд хамааралгүй, харьцангуй бие даасан орчинд үйл ажиллагаагаа явуулах тогтолцоог бүрдүүлсэн байна.

Төв банк бол мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч

Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг Монгол Улсын Төв банк гэнэ. Монгол Улсын Төв банкныг Монголбанк гэж нэрлэнэ. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад орших бөгөөд өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ. Монголбанк өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ. Үүнд:

⁶ Д.Моломжамц, “Санхүү, мөнгө зээлийн харилцаа”, хоёр дахь хэвлэл, УБ., 2008, х.551-566

⁷ Тухайн үед батлагдсан банкны тухай хуулинд энэхүү зүйлийг тусгасан байсан бөгөөд одоогийн шинэчилэн найруулсан банкны тухай хуулинд энэ зүйл байхгүй болно.



Төв банкны үйл ажиллагаа					
1/ мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах;	2/ мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх	3/ Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;	4/ банкны үйл ажиллагаанд хяналт тавих;	5/ банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;	6/ гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж, удирдах.

Төв банк бол мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах онцгой эрх бүхий цорын ганц субъект болох нь

Төв банкны тухай хуулийн 2-р бүлгийн 6-р зүйлд Монголбанк Монгол Улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онцгой эрх эдэлнэ.

Монгол Улсын Төв банк УИХ, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газартай харилцах харилцаа

Төв банкны тухай хуулийн 30 дугаар зүйлд Монголбанк Улсын Их Хуралтай, 31 дүгээр зүйлд Засгийн газартай, 311 дүгээр зүйлд Санхүүгийн зохицуулах хороотой харилцах харилцааг тус тус хуульчилан заасан байдаг. Хүснэгтийг харна уу.

№	Төв банк (Монголбанк)-ны харилцаа	Хуулийн заалтууд
1	Төв банкны Улсын Их Хуралтай харилцах харилцааг	<ol style="list-style-type: none"> 1. Монголбанк төрийн мөнгөний бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө, зээлийн байдлын талаар улирал тутам, төрийн мөнгөний бодлогод тодорхойлсон үзүүлэлт нь Монголбанкны үйл ажиллагаанаас үл шалтгаалан эдийн засагт бий болсон нөхцөл байдлаас хамааран хэрэгжээгүй тохиолдолд, санхүүгийн тайлангаа аудитын санал, дүгнэлт болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийн хамт жил бүр Улсын Их Хуралд танилцуулна. 2. Улсын Их Хурал Монголбанкны үйл ажиллагаа хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, Төв банкны тухай хуулийн 271 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 4 дэх заалт, 30 дугаар зүйлийн 1-3 дахь хэсэгт заасан тайлан, танилцуулгатай танилцах бөгөөд ингэхдээ төрийн мөнгөний бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нь оролцохгүй.

2	Төв банкнаас Засгийн газартай харилцах	<ol style="list-style-type: none"> 1. Монголбанкнаас Засгийн газартай харилцах үйл ажиллагаа нь Төв банкны тухай хуулийн 17, 18 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар зохицуулагдана. 2. Монголбанк Засгийн газраас хараат бус байна. 3. Засгийн газрын шийдвэр төрийн мөнгөний бодлогод харшилж байвал Монголбанк энэ талаар Засгийн газарт мэдэгдэнэ. 4. Монголбанкны Ерөнхийлөгч Монголбанк болон банкны үйл ажиллагаатай холбогдох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхэд зөвлөх эрхтэй оролцож болно. 5. Монголбанк мөнгөний статистик мэдээлэл болон жилийн тайлангаа Засгийн газарт хүргүүлнэ.
3	Төв банкнаас Санхүүгийн зохицуулах хороотой харилцах	<ol style="list-style-type: none"> 1. Монголбанк нь Санхүүгийн зохицуулах хороо болон санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах гурван талт харилцан ойлголцлын санамж бичиг үйлдэнэ. 2. Монголбанк Санхүүгийн зохицуулах хороотой харилцахдаа энэ хуулийн 311 дүгээр зүйлийн 1-д заасан санамж бичгийг удирдлага болгоно.

Монголбанкнаас Эрдэнэсийн санг эрхлэх нь

Монголбанкны эрхлэх үйл ажиллагааны хүрээнд хамаарах улсын эрдэнэсийн санг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, захиран зарцуулахтай холбогдсон эрх зүйн харилцааг 1994 онд батлагдсан Эрдэнэсийн сангийн тухай хуулиар зохицуулж байна. Улсын эрдэнэсийн санд байгаа эрдэнэс, үнэт металл, эрдэнийн чулуу зэрэг нь төрийн өмч бөгөөд тэдгээрийг үндсэн болон гүйлгээний сан гэж 2 хэсэгт хуваан захиран зарцуулах талаар төрийн байгууллагуудын гүйцэтгэх эрх, үүргийг энэхүү хуулиар зохицуулахаар тусгасан байна. Эрдэнэсийн сангийн байнгын хэсэгт байх эрдэнэсийн нэр төрөл, тоо хэмжээг тогтоох, гүйцэтгэлийн тайланг батлах, гүйлгээний сангаас жил бүр зарцуулах хэмжээг тогтоох, эрдэнэсийн санд авах үнэт металл, эрдэнийн үнэт чулууны хэмжээг Монголбанкинд тогтоож өгөх эрх хэмжээ УИХ-д бий. Харин Монголбанк эрдэнэсийн санг эрхлэх, сангийн бүртгэл тооцоог хөтлөх, санг арвижуулах арга хэмжээ авах, мөн Монгол улсын нутаг дэвсгэр дээр эрдэнэс эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь олборлосон үнэт металл, байгалийн төрц, эрдэнийн чулууг улсын эрдэнэсийн санд худалдах, үнэт металл, эрдэнийн чулуугаар хийсэн түүх, соёлын дурсгалт зүйл эзэмшиж байгаа бол түүний жинхэнэ эхийг эрдэнэсийн санд хадгалуулах үүрэгтэй байхаар тусгасан байдаг.



Хоёр. Семинар

Бодлого

№	Үзүүлэлтүүд	№	Үзүүлэлтүүд
1	Мөнгөжсөн алт, үнэт металл	9	Эдийн засгийн яамны харилцах
2	Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	10	Гадаадын банкуудад байршуулсан хадгаламж
3	Дотоодын банкуудын харилцах	11	Үндсэн хөрөнгө
4	Гадаад пассив	12	Бэлэн мөнгө
5	Гадаадын компанийн үнэт цаасанд хийсэн хөрөнгө оруулалт	13	Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл
6	Банкуудад олгосон зээл	14	Дүрмийн сан
7	Төв банкны гаргасан үнэт цаас	15	Нөөцийн сан
8	Сангийн яаманд олгосон урьдчилгаа	16	Дэлхийн банкны үнэт цаас

Шийдвэрлэх асуудал:

1. Дээрх үзүүлэлтүүдийг ашиглан Төв банкны тэнцлийн үзүүлэлтүүдийг актив, пассиваар нь ялга.
2. Эдгээр үзүүлэлтүүдээс Төв банкны үйл ажиллагаанд зөрчилдөх үзүүлэлтүүдийг олж тогтоон, учир шалтгааныг тайлбарла.

Хяналтын асуулт:

1. Хоёр шатлалт банкны тогтолцоо - Төв банкны үүсэл хөгжлийн тухай ярилцана уу?
2. Төв банкны хараат бус байдал, түүнийг хуульчлан баталгаажуулах шаардлагыг тайлбарлана уу.
3. Төв банкны чиг үүрэг ба эрхлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тайлбарлана уу.

СЭДЭВ 8. БАНКНЫ ХАРИЛЦАГЧ, ТҮҮНИЙ ЭРХ АШИГ

Сэдвийн зорилго: Санхүүгийн системийн эрүүл, найдвартай байдлыг хангахын тулд харилцагч (хэрэглэгч)-ийн эрх ашгийг хамгаалсан оновчтой тогтолцоо бүрдүүлэх, түүнд Төв банкны гүйцэтгэх үүрэг, банкуудаас авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, компанийн сайн засаглалын үр нөлөөний харилцан хамаарлын тухай мэдлэг олгож, холбогдох асуудалд хууль зүйн дүгнэлт хийх чадвартай болгоход зорилго оршино.

Түлхүүр үг: Банкны харилцагч (хэрэглэгчийн)-ийн эрх ашиг, банкны мэдээллийн ил тод байдал, хадгаламжийн даатгал, банкны хяналт шалгалтын үр нөлөө.

Нэг. Тойм лекц:***Банкны харилцагч (хэрэглэгчийн)-ийн эрх ашиг***

Банкны харилцагч (хэрэглэгчийн)-ийн эрх ашиг, тэдний санхүүгийн боловсролыг санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах үүрэгтэй Төв банкны хувьд анхаарвал зохих асуудлын нэг юм.

Банкны харилцагч (иргэд, өрх айл, хуулийн этгээд гэх мэт) нь бүтээгдэхүүн, үйлчилгээний зардал, урамшуулал, эрсдэлийн талаар хангалттай мэдээлэл авч чаддаг, банк нь эдгээр мэдээллийг ил тод, ойлгомжтойгоор өөрийн харилцагчдаа хүргэдэг бол тухайн улс оронд хэрэглэгчийн эрх ашиг хүчтэй хамгаалагдсан хэмээн дүгнэгддэг.

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний тухай мэдээлэл нь харилцагчийг ухаалаг санхүүгийн шийдвэр гаргахад суурь өгөгдөл, гол хэрэгсэл болж өгдөг.

Харилцагчийн эрх ашгийг хамгаалах, тэдний санхүүгийн боловсролыг дээшлүүлэх нь санхүүгийн системийн эрүүл, найдвартай байдлыг хангахад чухал ач холбогдолтой болно.

Банкны харилцагчийн эрх ашиг, санхүүгийн боловсрол хамтдаа санхүүгийн системд итгэх олон нийтийн итгэлийг бий болгож, санхүүгийн системийн хөгжилд дэмжлэг үзүүлдэг хадгаламж болон урт хугацаатай санхүүгийн хөрөнгө оруулалтыг урамшуулж байдаг билээ.

Харилцагчийн эрх ашиг сайтар хамгаалагдсан байх нь олон нийтээс санхүүгийн системийг илүү ил тод, үр ашигтай байлгахыг шаарддаг тул санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэхэд томоохон нөлөө үзүүлж, санхүүгийн системийн зохистой өсөлтийг бий болгоход чухал үүрэгтэй.

Банкны зээлийн өсөлт хурдацтай, нийт хадгаламжийн дунд жижиг хадгаламж эзэмшигчдийн эзлэх хувь байнга өндөрсөж байгаа манай улсын хувьд хэрэглэгчийн эрх ашиг, хэрэглэгчийн санхүүгийн мэдлэг, боловсролыг илүү анхаарах шаардлагатай байна.

Монголбанк нь банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах зорилгыг хангаж ажиллахыг Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасан энэхүү зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлж, хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор банк байгуулах зөвшөөрөл олгох, түүний өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах болон үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм, журам шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж байна.



Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуульд хэрэглэгчийн эрхийг хамгаалах зарчмыг “Хэрэглэгч нь бараа, ажил, үйлчилгээний талаар үнэн зөв мэдээлэл олж авах, хэрэглээний соёл эзэмших боломжоор хангагдсан байх” хэмээн тодорхойлсон.

Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан “Мөнгөн хадгаламж, зээлийн хүү болон үнэт цаасны орлого, хямдруулалтын хувь хэмжээг бодох аргачлал”, “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам” нь банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн эх сурвалж болно.

Компанийн нийгмийн хариуцлага, компанийн засаглалын суурь зарчим (“шударга байдал”, “хариуцлагатай байх”, “ил тод байдал”, “хариуцлагатай, үнэн зөв тайлагнал”) -уудын хэрэгжилтийн нэг гол индикатор бол харилцагчийн эрх ашгийг хамгаалах оновчтой тогтолцоо, тэдний хэрэглээнд шаардагдах мэдээлэл тодорхой байх ёстой бөгөөд энэ нь банкны өрсөлдөх чавдар, тогтвортой хөгжлийг илэрхийлнэ.

Мэдээллийн ил тод байдал- хариуцлагатай, үнэн зөв тайлагнал- харилцагчийн эрх ашгийг хамгаалахад чухал нөлөө үзүүлэх нь

Банкууд зээл, хадгаламжийн бүтээгдэхүүний төрөл, тэдгээрийн хүү, хугацаа зэрэг мэдээллийг цахим хуудас, мэдээллийн ажилтнууд, зар сурталчилгаа, танилцуулгаар дамжуулан олон нийтэд мэдээлж байна. Гэвч ихэнх банкуудын шимтгэл, хураамж, торгуулийн талаар харилцагчид ойлгомжтой, ил тод мэдээлэхгүй байхын зэрэгцээ зарим банкууд хүү, шимэтгэлийн талаар зээлийн гэрээнд “хүү, шимтгэлийн ерөнхий нөхцлийн дагуу төлбөр төлнө” гэсэн тодорхой бусаар заах, нөгөө хэсэг нь огт тусгахгүй байна.

Энэ нь зээлдэгчдэд шимтгэл, хураамжтай холбоотой мэдээллийг бүрэн гүйцэд хүргэх боломжийг хязгаарлаж, улмаар иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш байх зарчим болоод гэрээний эрх чөлөөнд харш үйлдэл болно.

Банкны харилцагчийн санхүүгийн боловсрол тааруухан байгаа энэ үед банкны мэдээллийн ил тод байдал, тайлагнал нь санхүүгийн үйл ажиллагааг нэмэгдүүлж, эрсдлийг бууруулж, эрүүл өрсөлдөөнийг бий болгосноор санхүүгийн системийн тогтвортой, найдвартай үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх учир банкуудын мэдээллийн ил тод байдалд анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Одоогоор банкууд нь зээл олгосны шимтгэл, зээлийн хугацаа сунгасны шимтгэл, зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулсны шимтгэл, харилцагчийн хүсэлтээр зээлийн болон барьцаа хөрөнгийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсны

шимтгэл гэгчийг харилцагчаас авч байгаа нь Банкны тухай хуулийн 10.1 дүгээр зүйл⁸, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйл⁹, 24 зүйлийн 1¹⁰, Монголбанкны Ерөнхийлөгчийн 1997 оны 1 сарын 17-ны өдрийн 23 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгөн хадгаламж, зээлийн хүү, үнэт цаасны орлого, хямдруулалтын хувь, хэмжээг бодох аргачлал”-ын нэг дэх заалт, Өрсөлдөөний тухай хуулийн 12.1.10¹¹-т “хууль ёсны ашиг сонирхолд харшлах болон хэрэглэгчийг хууль бусаар хохироох худалдааны арга хэрэглэх”-ийг хориглоно гэж заасныг тус тус зөрчсөөр байна.

Хадгаламжийн даатгал

Хадгаламжийг даатгуулах зорилго нь хадгалуулагчийн хөрөнгийн аюулгүй байдал, хүссэн цагтаа хадгаламжаа захиран зарцуулах боломжид итгэх итгэлийг хангах явдал юм. Хадгаламжийн даатгал нь хадгалуулагчийн хөрөнгийг хамгаалах, банкны системийн тогтвортой байдлыг хангахад чухал байр суурийг эзэлдэг. Мөнгөн хадгаламжийн даатгалыг албан ёсны ба албан бус гэж ангилдаг.

Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль нь банкны мөнгөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилготой бөгөөд банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоож, хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж байна. Ийнхүү хуульчлагдсан мөнгөн хадгаламжийн тогтолцоог “хадгаламжийн албан ёсны даатгал” гэнэ.

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжид төрөөс баталгаа гаргаж, холбогдох харилцааг Банкн дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулиар 2008-2012 онуудад зохицуулж байсан нь хадгаламжийн даатгалын албан бус хэлбэр юм.

Үүнээс өмнө манай улсад хадгаламжийн албан бус даатгалын тогтолцоог төрөөс үүсгэн байгуулж, банкны бүтцийн өөрлөлтийн хүрээнд 1996-1999 онуудад төрөөс нийт 70 гаруй тэрбум төгрөгийн зардал гаргасан байна. Энэ нь тухайн үеийн төсвийн нийт орлогын 40 орчим хувийг, ДНБ-ний 7 орчим хувийг эзэлж байлаа. Үүнд холбогдох зардлыг олон улсын байгууллагаас авсан зээлээр санхүүжүүлсэн нь

8 Банк иргэн, хуулийн этгээдэд өөрийн болзол, нөхцөлийн дагуу зээл олгож болох бөгөөд зээлийн хүүг өөрөө тогтооно.

9 Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид “зээлдүүлэгч” гэх/ тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэж төлөгдөх барьцаа, эсхүл батлан даалттайгаар өөрийн болон түүнд хадгалуулсан бусдын мөнгөн хөрөнгийн зохих хэсгийг өөрийн нэрийн өмнөөс бусад этгээд /цаашид “зээлдэгч” гэх/-д олгохыг банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох /цаашид “зээл” гэх/ гэнэ.

10 Зээлийг ашигласан хугацаанд гэрээнд заасан хэмжээгээр тооцсон зээлдэгчийн хариу төлбөр буюу зээлийн үнэ нь зээлийн хүү болно.

11 хууль ёсны ашиг сонирхолд харшлах болон хэрэглэгчийг хууль бусаар хохироох худалдааны арга хэрэглэх.



гадаад өрийн дарамтыг нэмэгдүүлж, улс орны эдийн засагт таатай бус алхам болж байсан юм.

Хадгаламжийн даатгалын албан бус тогтолцоо нь банкуудын санхүүгийн хариуцлагыг сааруулж, тэдний харилцагчийн өмнө хүлээвэл зохих хариуцлагыг нь төр үүрч, төсвийн тэнцэлд сөрөг нөлөө үзүүлсэн.

Даатгуулах эх үүсвэрийн хувьд гол төлөв бага хэмжээний хадгаламжтай, өөрийн эрх ашгийг хамгаалах чадвар нь хязгаарлагдмал, санхүүгийн боловсрол сул, жижиг хадгаламж эзэмшигчдийн мөнгийг хамруулдаг бөгөөд даатгалд хамруулах эх үүсвэрийн хэмжээг нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээтэй уялдуулан тогтоодог байна.

Зарим орны хадгаламжийн даатгалд хамрагдвал зохих хадгаламжийн хэмжээ:

дд	Тухайн улс, түүний хадгаламжийн даатгалыг эрхлэдэг байгууллагын нэр	Даатгалын хэмжээ
1	Канад: Хадгаламжийн даатгалын Канадын корпораци	60 000 канад доллар
2	Япон: Хадгаламжийн даатгалын корпораци	10 сая иен
3	Швейцарь: Швейцарийн банкны холбоо	30 000 швейцарь франк
4	Их Британи: Хадгалуулагчдыг хамгаалах сан	Нэг хадгалуулагчийн 20 000 фунт стерлинги хүртэлх хадгаламжийн 75 хувь
5	АНУ: Хадгаламжийн даатгалын холбооны корпораци	Нэг хадгаламж эзэмшигчид 100 000 ам.доллар
6	Монгол: Хадгаламжийн даатгалын корпораци	20 сая хүртэл төгрөг

Хоёр. Семинар

Тайлбар. Оюутан нь энэ семинарт багаар оролцох бөгөөд өгөгдсөн бодлогыг онол, хууль тогтоомжийн практик хэрэглээний хүрээнд шийдвэрлэнэ. Баг тус бүр нэг нэг шийдвэрлэх асуудлыг хуваарилан авч хэлэлцүүлэг хийх, эсхүл нийт асуудлыг баг бүр хийгээд мэтгэлцээн өрнүүлэх аргаар семинар явагдаж, оюутны бие даан ажиллах чадварыг хөгжүүлнэ.

Бодлого 1:

Өгөгдөл: Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас доорхи агуулга бүхий “Зөрчил арилгуулах тухай” улсын байцаагчийн албан шаардлагыг НЭГЭН банкны Гүйцэтгэх захиралд 2011 онд хүргүүлжээ. Үүнд:

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудаас аж ахуй нэгж, иргэдэд зээл олгож буй байдал, зээлийн бодолт, байгуулж буй гэрээ нь Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нийцэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийг тус тус үндэслэн хяналт шалгалтын ажлыг хийсэн болно.

Хяналт шалгалтаар арилжааны банкууд аж ахуйн нэгж, иргэдэд зээл олгох явцдаа нэр бүхий дараахь шимэтгэлийг авч байна.

1. зээл олгосны шимтгэл,
2. зээлийн хугацаа сунгасны шимтгэл,
3. зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулсны шимтгэл,
4. харилцагчийн хүсэлтээр зээлийн болон
5. барьцаа хөрөнгийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсны шимтгэл

Эдгээр шимэтгэлийн тухай харилцагч тухайн банкныг сонгох үед, тэр бүү хэл гэрээ байгуулагдсан хойно ч тодорхой бус байдаг байна. Өөрөөр хэлбэл банкууд нь зээлийн гэрээнд ил тод тусгаагүй “зөвхөн хүү, шимтгэлийн ерөнхий нөхцлийн дагуу төлбөр төлнө” гэж оруулсан гэжээ.

Энэ нь “Банкны тухай хуулийн 10.1, “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай” хуулийн 20 дугаар зүйл, 24 зүйлийн 1, Монголбанкны Ерөнхийлөгчийн 1997 оны 1 сарын 17-ны өдрийн 23 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгөн хадгаламж, зээлийн хүү, үнэт цаасны орлого, хямдруулалтын хувь, хэмжээг бодох аргачлал”-ын нэг дэх заалт, “Өрсөлдөөний тухай” хуулийн 12.1.10 дахь заалтын “хууль ёсны ашиг сонирхолд харшлах болон хэрэглэгчийг хууль бусаар хохироох худалдааны арга хэрэглэх”-ийг хориглоно гэж заасныг тус тус зөрчсөн нь тогтоогдсон гэж үзжээ.

Тэрбанкнаас энэхүү шаардлагыг хүчингүй болгуулахаар шаардсан нэхэмжлэлийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд гаргасан.

Нэхэмжлэлийн агуулга: ... Улсын байцаагчийн албан шаардлага, шийтгэвэр нь хууль зүйн үндэслэлгүй ...

... Төв банкны бодлогын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 1997 оны 23 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгөн хадгаламж, зээлийн хүү, үнэт цаасны орлого,



хямдруулалтын хувь, хэмжээг бодох аргачлал”-ын нэг дэх заалтад зээлийн шимтгэл авахыг хориглосон зохицуулалт тусгагдаагүй.

... Олон улсын банк, санхүүгийн салбарт зээлийн хүүгийн зэрэгцээ шимтгэл авах нь түгээмэл, зайлшгүй нөхцөл байдаг. ...

Дээрх нэхэмжлэлийг болон бусад 9 нэр бүхий арилжааны банкуудын агуулга нь адил нэхэмжлэлийг 2011 оны *** тоот шүүхийн шийдвэрээр тус тус бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон байна.

Гэвч эдгээр 10 банк давж заалдсан бөгөөд 2012 оны *** тоот захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдаанаас дараахь агуулга бүхий магадлал гаргасан. Үүнд:

Тогтоох нь: ... Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2011 оны *** дугаар шийдвэрийг хүчингүй болгож, Төв банкны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 1, 2, 24 дүгээр зүйлийн 1, Төрийн хяналт шалтгалтын тухай хуулийн 10.9.10-т заасныг тус тус баримтлан нэгэн банкнаас ... холбогдуулан гаргасан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч нарын 2011 оны “Зөрчил арилгуулах тухай” 5 албан шаардлагууд, ... нэр бүхий банкуудыг тус бүр 10,000,000 арван сая/ төгрөгөөр торгосон ... шийдвэрүүдийг тус тус хүчингүй болгосугай. ...

Шийдвэрлэх асуудал:

1. “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах Монгол Улсын тогтолцоо” сэдвээр оюутнууд багт хуваагдаж, холбогдох хуулиудад хяналт шинжилгээ (мониторинг) хийж, дүгнэлт гаргах,
2. Банкууд нь шимтгэл, хураамж, торгуулийн талаар тэр бүр ил тод мэдээлэхгүй байгаа нь компанийн засаглалын зарчмуудтай нийцэж байгаа эсэхэд хууль зүйн дүгнэлт бичих, үүнд хамгийн багадаа 7 банкны зээлийн гэрээ, мэдээлэлд харьцуулсан судалгаа хийх,
3. Харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд төр, банк, санхүүгийн бусад сектороос авч хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагааны санал дүгнэлт боловсруулах,
4. Нэр бүхий 10 банкны давж заалдсантай холбогдуулан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2012 оны *** тоот хуралдаанаас гаргасан магадлалд хууль зүйн дүгнэлт бичих,
5. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2012 оны *** тоот хуралдаанаас гаргасан магадлалыг хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлүүлэх гомдолын төсөл бичих,

Хяналтын асуулт:

1. Харилцагчийн эрх ашгийг хамгаалах оновчтой тогтолцоо, тэдний хэрэглээнд шаардагдах мэдээлэл тодорхой байх ёстой ба банкны өрсөлдөх чавдар, тогтвортой хөгжилтэй харилцан хамааралтай болохыг тодорхойлох,
2. Харилцагчид ямар төрлийн мэдээлэл ил тод, ойлгомжтой байхыг шаарддаг вэ?
3. Хадгаламжийн даатгалын эдийн засаг дахь үр нөлөөг тайлбарлах,

СЭДЭВ 9. БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

Сэдвийн зорилго: Банкны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд банкны үйл ажиллагааг хянан шалгах, хяналт шалгалтын төрөл, хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч субъектийн эрх хэмжээний тухай мэдлэг олгоход энэ хичээлийн зорилго оршино.

Түлхүүр үг: Банкны хяналт шалгалт, БАЗЕЛ-ын зарчим, банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.

Нэг. Тойм лекц:**Банкуудын үйл ажиллагаанд тавих хяналт, түүний зохицуулалт**

Улс орнуудын хууль тогтоомжийн зохицуулалтаас хамаарч банкны хяналт шалгалтыг өөр өөр байгууллагууд хэрэгжүүлэх боловч дараах 3 хэлбэр нилээд түгээмэл тархжээ. Үүнд: Сангийн яам /Япон/, Төв банк /Монгол/, бусад буюу хяналт шалгалтын байгууллагууд /ХБНГУ/.

Монголбанк нь Төв банкны тухай хуулийн дагуу хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор банк байгуулах зөвшөөрөл олгох, түүний өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах болон үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм, журам шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

Банкны хяналт шалгалт хэрэгжүүлэгч байгууллага нь зорилго, үүрэг хариуцлага нь тодорхой байвал банкны хяналт шалгалтын тогтолцоо үр дүнтэй байна. Энэ төрлийн байгууллага бүр үйл ажиллагааны хувьд хараат бус, хүрэлцэхүйц нөөц хөрөнгөтэй байхыг шаарддаг билээ. Банкнийг нэгдсэн байдлаар бүхэлд нь хянан шалгах чадвар бол банкны хяналт шалгалтын үйл ажиллагааны чухал асуудал болно.

Банкны үр дүнтэй хяналт шалгалтын тогтолцоо нь зайнаас хийх хяналт (офсайт), газар дээрх (онсайт) шалгалтын нийлбэр цогцоос бүрдэнэ.


Газар дээрх хяналт шалгалтаар банкны активын чанар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, ашигт ажиллагаа, төлбөрийн чадвар, эрсдэлийн түвшин болон компанийн



засаглалын байдлыг тус тус шалгаж, тухайн банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд дүгнэлт өгнө.

Газар дээрх хяналт шалгалтыг эрх бүхий этгээдийн¹² баталсан шалгалтын удирдамжийн дагуу шалгалтын ажлын хэсэг тухайн банкин дээр ажиллаж, шалгагдвал зохих хугацаанд хамаарах баримтуудад тулгуурлан иж бүрэн шалгана.

БАНКНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОГТОЛЦОО



Банкнаас сар тутам ирүүлвэл зохих тайлан мэдээнд шинжилгээ хийж, банкны санхүү, төлбөрийн чадварын байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, үүсч болзошгүй эрсдэлийн түвшинг тогтоох, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үйл ажиллагааг банкны үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих гэж ойлгоно.

Банкны хяналт шалгалтын байгууллага нь хяналт шалгалтын мэдээллийг газар дээрх шалгалт эсхүл хөндлөнгийн аудитаар баталгаажуулна. Аливаа хяналт шалгалт нь оновчтой, үр өгөөжтэй, байнгын, тасралтгүй байх шаардлагыг өөртөө агуулдаг.

Төв банкнаас хэрэгжүүлж буй хяналт шалгалт нь төрийн хяналт шалгалтын нэг төрөл болно.

¹² Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч



Монголбанкны хяналт шалгалтыг улсын байцаагчийн эрх бүхий Монголбанкны хянан шалгагч, хянагч хэрэгжүүлнэ. Тэдний бүрэн эрх, баталгааг хуулиар тогтоодог.

Хянан шалгагчийн мэдээлэл солилцох, тэдгээр мэдээллийн нууцлалыг хамгаалах тогтолцоог бий болгох нь банкны хяналт шалгалтын чухал асуудлын нэг болно.

Банк нь эрх бүхий этгээдийг бие даасан хараат бусаар хяналт шалгалт хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүргийг хүлээнэ.

Монголбанк нь хяналт шалгалт хийхдээ шаардлагатай гэж үзвэл Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороотой хамтран нэгдсэн хяналт шалгалт хийх бөгөөд түүнд хамрагдах хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгдсэн байдлаар гаргаж үнэлэлт, дүгнэлт өгдөг болно.

Тухайн орны банк гадаад улсад үйл ажиллагаа явуулдаг тохиолдолд тэрхүү өөр улс орон дахь салбар, нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг мөрдөхийг шаардаж, нэгдсэн хяналт шалгалтыг хийнэ. Хяналт шалгалтыг нэгдсэн байдлаар хийхдээ холбогдох бусад хяналт шалгалтын байгууллага, ялангуяа гадаад орны ижил төрлийн байгууллагатай холбоо тогтоож мэдээлэл солилцоно хэмээн тус тус БАЗЕЛ-ын хорооноос баталсан “Банкны хяналт шалгалтын үндсэн зарчим”-д заажээ.

Банкуудад хийсэн шалгалтын материал, шийдвэрийн төсөл, илэрсэн зөрчил болон банкны бусад асуудлыг хэлэлцэх үйл ажиллагааг шуурхай хэрэгжүүлэх зорилго бүхий Хяналт шалгалтын зөвлөл эрх бүхий хяналт шалгалтын байгууллагад ажиллаж болно.

Хяналт шалгалтаар хууль тогтоомж, зөрчсөн бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан Монголбанкнаас албадлагын арга хэмжээ авна.




БАЗЕЛ-ын хорооноос банкны хяналт шалгалтанд удирдлага болговол зохих зарчмыг баталдаг бөгөөд тэдгээрийг банкны хяналт шалгалтанд баримтална. 1988 оноос БАЗЕЛ I, 2007 оноос БАЗЕЛ II тус тус мөрдөгдөж эхлэсэн бол БАЗЕЛ III хэдийн батлагдсан бөгөөд 2018 он гэхэд банкны хяналт шалгалтанд нэвтэрсэн байхаар төлөвлөгдөөд байна. БАЗЕЛ зарчим нь “засаглалын зохистой удирдлага”, “зах зээлийн эрсдэл”, “зээлийн эрсдэл”, “үйл ажиллагааны эрсдэл”, “дотоод аудит”, “мөнгө угаалт”, “нэгдсэн хяналт шалгалт” гэх мэт олон асуудлыг хамарсан 25 зарчмын нэгдэл болно.

Базел III-ын талаархи товч танилцуулга



Банкны ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Гүйцэтгэх удирдлагын дотоод аудитын газар нь хууль тогтоомж, тухайн банкны эрх бүхий этгээдээс батлан гаргасан эрх зүйн баримт бичгийн хүрээнд банкны хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Түүнчлэн аудитын байгууллага банкны хяналтын субъектэд хамаарч, гадаад аудит хийнэ.



Банк нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг зохистой харьцааны “өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт”, “төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа”, “зээлийн төвлөрлийн эрсдлийн зохистой харьцаа”, “гадаад валютын ханшийн эрсдлийн зохистой харьцаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу тооцон ажиллана.





Хоёр. Семинар

Тайлбар. Оюутан нь энэ семинарт багаар оролцох бөгөөд өгөгдсөн бодлогыг онол, хууль тогтоомжийн практик хэрэглээний хүрээнд шийдвэрлэнэ. Баг тус бүр нэг нэг шийдвэрлэх асуудлыг хуваарилах авч өргөн хэлэлцүүлэг хийх, эсхүл нийт асуудлыг баг бүр хийгээд мэтгэлцээн өрнүүлэх аргаар семинар явагдаж, оюутны бие даан ажиллах чадварыг хөгжүүлнэ.

Бодлого 1: НЭГЭН банк нь өөрийн дүрмэндээ “Монголбанкны журмууд мөн Компанийн тухай хуулинд заасны дагуу салбар, нэгж нээх” гэж заажээ.

Тэрхүү банк БНСУ-д төлөөлөгчийн газар нээх эрхийг БНСУ-ын Санхүүгийн хяналтын хорооноос албан ёсоор авч, НЭГЭН банкны Гүйцэтгэх захирлын тушаал гарсанаар гадаад улсад өөрийн төлөөлөгчийн газраа нээн ажиллуулах болсон байна.

Тэрхүү төлөөлөгчийн газар нь БНСУ-ын харьяалах Татварын албанаас аж ахуйн нэгжийн гэрчилгээ авчээ.

НЭГЭН банкны Гүйцэтгэх захирлын тушаалын хавсралтаар “БНСУ дахь Төлөөлөгчийн газрын дүрэм”, “Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны журам” тус тус баталжээ.

НЭГЭН банкны гадаад улс дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд хамаарах ГЗ-ын тушаал, холбогдох бусад баримтуудыг нягтлан үзэхэд БНСУ дахь төлөөлөгчийн газар нь нилээдгүй хугацаанд БНСУ-д амьдардаг монголчуудад мөнгөн хадгаламжийн данс нээх үйл ажиллагааг эрхэлсэн байна.

Энэ нь Монгол улсын холбогдох хууль тогтоомж, НЭГЭН банкны эрх зүйн баримт бичгүүд, НЭГЭН банк ба түүний корреспондент харилцаатай БНСУ-ын нэр бүхий банкуудын хооронд байгуулагдсан харилцан ойлголцлын санамж бичиг, гэрээг зөрчсөн, БНСУ-ын Санхүүгийн хяналтын хорооноос олгосон зөвшөөрөлд үл хамаарах үйл ажиллагаа бөгөөд эрх зүйн болон бизнесийн ёс зүйгүй үйлдэл гэж хянан шалгагч дүгнэсэн байна.

Шийдвэрлэх асуудал:

НЭГЭН банкны БНСУ дахь төлөөлөгчийн газраас БНСУ-д амьдардаг монголчуудад холбогдох данс нээсэн нь гэсэн хэм хэмжээг зөрчсөн гэж хянан шалгагч үзжээ. Үүнд:	
Зөрчсөн хууль тогтоомж, түүний заалт	Хэм хэмжээ
1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.2.1 дэх заалт	15.1 Энэ зүйлд заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ. 15.2.1 банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх
2. Компанийн тухай хуулийн 7.2 дахь заалт	7.2 Компанийн төлөөлөгчийн газар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулна.
	Зүүлт: 7.1. Компанийн салбар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг тусгай нэгж бөгөөд компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг гүйцэтгэж болно.
3. Банк, түүний нэгжийн журмын XXX заалт	
БНСУ-ын холбогдох хууль тогтоомж	Банкны үйл ажиллагаа нь эрх бүхий этгээдийн тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх ажил үйлчилгээнд хамаарах ба тэдгээрийг зөвшөөрөлгүй эрхлэхийг улс орнуудын хууль тогтоомжоор хориглодог. Түүнчлэн эрх бүхий этгээдээс олгосон тусгай зөвшөөрлийг урвуулан ашиглах нь тодорхой төрлийн эрх зүйн зөрчил болно.

1. НЭГЭН банк “Банк, түүний нэгжийн журам”-ын хэд дэх заалтын ямар хэм хэмжээг зөрчсөн гэж хянан шалгагч дүгнэсэн бэ? Хүснэгтийн холбогдох хэсэгт бичнэ үү.
2. БНСУ-ын Санхүүгийн зохицуулах хорооны эрх хэмжээг тус улсын холбогдох хууль тогтоомжид хэрхэн тодорхойлсон тухай судалж, Монголбанк ба өөрийн орны Санхүүгийн зохицуулах хорооны эрх хэмжээтэй харьцуулсан судалгаа хийх,
3. НЭГЭН банк БНСУ дахь төлөөлөгчийн газарт холбогдох хянан шалгагчийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудалд хууль зүйн дүгнэлт гаргахыг Хуулийн болон Дотоод аудитын газартаа даалгасан байна. Хууль зүйн дүгнэлт бичнэ үү.
4. Дээрх тохиолдолд Монголбанк нь НЭГЭН банкны үйл ажиллагаанд нэгдсэн хяналт шалгалтыг хийх, БНСУ-ын ижил төрлийн байгууллагатай холбоо тогтоож мэдээлэл солилцох хэмээн эрхтэй болохоо тэмдэглэсэн байна. Энэ эрхийг эрх зүйн ямар эх сурвалжид заасан бэ?



5. БНСУ-д зөвшөөрөлгүйгээр банкны үйл ажиллагаа эрхэлсэн бол ямар хариуцлага ногдуулдаг болохыг судалж, өөрийн орны хууль тогтоомжтой харьцуулсан эрх зүйн хяналт шинжилгээ (мониторг) хийж, илтгэл бичих.
6. “Банкны хяналт шалгалтын БАЗЕЛ-ын үндсэн зарчим нь Монгол Улсын банкны хяналт шалгалтын тухай хууль тогтоомжид тусгагдсан” харьцуулсан судалгаа хийх,

Хяналтын асуулт:

1. Банкны үр дүнтэй хяналт шалгалтын тогтолцоог тодорхойлно уу?
2. БАЗЕЛ-ын хороо ба БАЗЕЛ-ын зарчмууд, тэдгээрийн банкны хяналт шалгалтанд үзүүлэх үр нөлөөний харилцан хамаарлыг ярина уу.
3. Банкны үйл ажиллагаанд ямар субъектүүдээс хяналт тавих эрхтэй вэ?

СЭДЭВ 10. МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН С.ЭРГИЙЛЭХ НЬ

Сэдвийн зорилго: Банк нь харилцагчаа танин мэдэх, мөнгө угаалтанд өртөхөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдлэг олгоно.

Түлхүүр үг: Банкны харилцагч, сэжигтэй гүйлгээ, мөнгө угаах.

Нэг. Тойм лекц:

Мөнгө угаах гэдэг нь гэмт хэрэг үйлдэж олсон орлого, хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдлах, түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсны болгож, гэмт үйлдлийг мөрдөн шалгах боломжгүй болгох үйл ажиллагаа бөгөөд үндэстэн дамнасан гэмт хэргийн нэг юм.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенци (Палермо, 2000)-д мөнгө угаах (money laundering) үйлдлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл эрх зүйн үндсэн зөрчлийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх,
2. Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах,
3. Тухайн эд хөрөнгийг олж авах үед түүнийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах,

4. Мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, үгсэн тохиролцох, үйлдэхийг завдах болон хамжих, хатгах, туслах болон зөвлөгөө өгөх гэж тодорхойлсон байдаг.

Олон улсын түвшинд мөнгө угаах гэсэн ойлголтыг өргөн хүрээнд хэрэглэдэг. Гэмт хэрэг үйлдэж олсон орлогоо нуусан, халхалсан, шилжүүлсэн үйлдэлд нь тухайн гэмт этгээдэд анх үйлдсэн гэмт хэрэг дээр нь давхардуулж ял, шийтгэл оноох эсхүл гэмт хэрэгт нь биечлэн оролцоогүй ч түүнээс олсон орлогыг хууль бус гэдгийг нь мэдсээр байж хүлээн авч, нууж, шилжүүлсэн бусад этгээдийг яллан шийтгэхэд мөнгө угаах гэсэн томъёоллыг ашигладаг.

Мөнгө угаахтай тэмцэхийн гол зорилго нь хэн нэгэн хүнд гэмт үйлдэлд нь давхар ял онооход бус харин бусад этгээдийг гэмт этгээдэд тус дэм үзүүлж болохуйц үйл ажиллагаа явуулахыг хязгаарлахад оршдог. Энэ нь нэг талаас мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх түүнд татагдан оролцохоос сэргийлэх ач холбогдолтой. Мөнгө угаах гэмт хэрэг нь байршуулах, тараах буюу гүйлгээнд оруулах, буцааж төвлөрүүлэх гэсэн 3 үе шаттайгаар хийгддэг тухай та бүхэн “Эрүүгийн эрх зүй” хичээлээр үзсэн билээ.

Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр нь терроризмыг санхүүжүүлэхтэй ижил төстэй явагддаг тул энэ хоёр гэмт хэргийг нягт холбоотой. Гэвч агуулгын хувьд энэ хоёр нь тусдаа явагддаг. Тухайлбал, мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны юм шиг харуулахыг зорьдог байхад терроризмыг санхүүжүүлэх нь хууль ёсны орлогоор хууль бус үйл ажиллагааг санхүүжүүлж байдаг.

Мөнгө угаах нь эдийн засаг, нийгмийн ихээхэн сөрөг үр дагавартай. Хууль бус мөнгө гаднаас орж ирсэн бол зорилгодоо хүрээд гэнэт орж ирсэн шигээ гэнэт буцаад гарна. Энэ нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг эвдээд зогсохгүй хямралд ч хүргэж болох юм. Түүнчлэн олон улсын тавцанд дотоодын банк, санхүүгийн байгууллагуудад нэр хүнд унах, банк, санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээг саатуулан шалгах, банкуудын хооронд байгуулагдсан харилцан ойлголцлын санамж бичиг, гэрээг зөрчсөнхэмээж хамтран ажиллахаас татгалзах хүртэлх арга хэмжээг гадаадын харилцагч банкууд авч болно.

Хэрэв хууль бус мөнгө дотоодынх бол энэ нь хээл хахууль, авлигыг гааруулах, шударга өрсөлдөөнийг үгүй хийх, шударгаар бизнес эрхлэгчдийг зах зээлээс шахаж монополь байдал бий болгох зэрэг олон сөрөг үр дагавартай. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо дутуу хөгжсөн орнуудыг мөнгө угаагчид ашиглах эрсдэл өндөр юм.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааг нэгтгэн төвлөрүүлж, олон улсын стандартыг боловсруулдаг байгууллага бол Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага буюу ФАТФ (Financial Action Task Force) болно. Энэ байгууллагыг 1989 онд “Их найм”



гэгддэг дэлхийн тэргүүлэх хөгжилтэй улсууд үүсгэн байгуулсан бөгөөд НҮБ-ийн конвенцууд, тогтоолуудыг хэрэгжүүлэх, олон улсын хүчин зүтгэлийг нэгтгэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.


Манай улс энэхүү байгууллагын бүс нутгийг хариуцсан салбар байгууллага болох Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн гишүүнээр 2004 онд элсэн орсон. ФАТФ нь “40+9” гэсэн зөвлөмжийг боловсруулан гаргасан бөгөөд энэ зөвлөмжөөр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд баримтлах наад захын шаардлага, стандартуудыг тодорхойлжээ. “40+9” зөвлөмжөөр улс орнуудаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг юуны өмнө гэмт хэрэгт тооцох шаардлагыг тавьдаг.

Мөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөх, шалгах, хууль бус гүйлгээ, орлогыг түдгэлзүүлэх, хураан авах эрх зүйн орчныг бүрдүүлэх, энэ ажлаар мэргэшсэн, төв байгууллагатай болох, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг банк, санхүүгийн байгууллагаар авахуулах, сэжиг бүхий гүйлгээний талаар эрх бүхий байгууллагад мэдээлэх зэрэг цогц арга хэмжээ бүхий тогтолцоог бүрдүүлэхийг улс орнуудад зөвлөдөг. Монгол Улсад 2006 оны 7 дугаар сард Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль батлагдаж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн үндэс суурь тавигдсан.

Улс орнуудад мөнгө угаалттай тэмцэх чиг үүрэг бүхий үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн, санхүүгийн мэдээллийг хүлээн авах, шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагуудад мэдээлэх үйл ажиллагааг эрхэлсэн агентлагууд ажиллах бөгөөд Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн тагнуулын байгууллага гэх зэргээр нэрлэдэг.

Манай улсад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн мэдээллийн алба (СМА) Монголбанкны бүтцэд 2006 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Монгол улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо



ФАТФ-ын гишүүн орнууд олон улсын стандартыг үл тоосон, хэрэгжүүлээгүй улс орнуудыг тусгай хар жагсаалтад оруулдаг. Жагсаалтад орсон улстай санхүү, эдийн засгийн ямар нэгэн харилцаа тогтоохгүй байхыг ФАТФ уриалдаг. Мөнгө угаалтанд өртөгдөх байдлын индексээр улс орнуудын мөнгө угаах гэмт хэргийн хохирогч нөхцөл хэр хэмжээтэй бүрэлдсэн байдал буюу мөнгө угаагчдийн сонирхолыг хэр татаж байгааг тодорхойлно.

Мөнгө угаалтанд өртөх байдлын индекс					
$I i = 3 BS i + GA i + Swift i - 3 CF i - CR i + 15$					
I	BS	GA	SWIFT	CF	CR
Index	Banking security	Government attitude	Society for Worldwideinterbank financial telecommunication	Refers to conflict	Stands forcorruption
Мөнгө угаалтанд өртөх байдлын индекс	Банк дахь харилцагчийн талаарх мэдээллийн нууцлалыг ил болгох тогтолцоо	Засгийн газрын хандлага	Банк хоорондын санхүүгийн алсын холбооны нийгэмлэг	Зөрчилдөөний түвшин	Авилгал



Мөнгө угаах гэмт хэргийг банкаар дамжуулан үйлдэх аргууд

1. Банкинд хадгаламж болон харилцах данс. Мөнгө гуйвуулагчаас хүлээн авсан бэлэн мөнгийг хувь хүний дансаар дамжуулан мөнгө хүлээн авагчид хүргэх мөнгөн гуйвуулгын албан бус хэлбэрээр дамжуулан мөнгө угаах,
2. Хууль бус банкны үйл ажиллагаа (албан бус шилжүүлгийн үйлчилгээ) Мөнгөн хөрөнгө, хуримтлалыг илрүүлэх боломжгүй болгон түүний жинхэнэ өмчлөгчийг тодорхойгүй байлгахад ашиглагддаг арга. Зарим улс орнуудад итгэлцэл дээр тогтдог албан бус болон хагас алба ёсны мөнгөн шилжүүлгийн механизмыг хуулиар хориглодог.
3. Оффшор банк болон олон улсын бизнесийн компани, оффшор компани ашиглах, Мөнгөн хуримтлалд хяналт тавих, захиран зарцуулах эрх бүхий хүнийг тодорхойгүй байлгах, тухайн улсын дотоодын хяналт шалгалтын байгууллагуудын хориг, дэглэм, хяналтад өртөхөөс зайлсхийхэд чиглэгдсэн мөнгө угаах арга юм.
4. Итгэмжлэгдсэн этгээд (банкны албан тушаалтан г.м.), гэр бүлийн гишүүд, гуравдагч этгээдийг ашиглах,

Банк нь мөнгө угаалтад өртөхгүй тулд “Харилцагчаа танин мэдэх” зарчмыг баримтлан ажиллах ёстой.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын компани, үнэт цаасны зах зээлд оролцогчид нь мэдээлэх үүрэг бүхий этгээд болно.

Хуулиар харилцагчийн талаарх мэдээллийг шалгах, зохих мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд үйлчилгээ үл үзүүлэх, дансанд хяналт тавих, сэжигтэй гүйлгээг мэдээлэх (20 сая буюу түүнээс дээш төгрөгийн үнийн дүнтэй гүйлгээ), гүйлгээг түдгэлзүүлэх, мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт (Дотоод журам, хяналтын ажилтан)-д хамаарах харилцааг зохицуулсан.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой эрх зүйн эх сурвалж

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, түүнтэй тэмцэхэд харилцагчийг таньж мэдэх талаар банкны баримтлах журам, НҮБ-ын тогтоолоор террорист гэж зарлагдсан байгууллага, этгээдийн нэрсийн жагсаалтыг гаргах, мэдээлэх, тэдгээрийн гүйлгээг түдгэлзүүлэх тухай журам, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкуудад хяналт шалгалт хийх журам, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор банкнаас эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх журам, Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон

бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам, Сэжигтэй гүйлгээг мэдээлэх маягт, Бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх маягт батлах тухай тогтоол, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалт хийх журам, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (FATF)-ын 40 зөвлөмж, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (FATF)-ын 9 зөвлөмж зэрэг болно.

Хоёр. Семинар

Бодлого. НЭГЭН банкны хувийн банкны алба нь Нина Ивановна, Ото Ямамота гэх 2 иргэнд их хэмжээний мөнгөн хөрөнгө бүхий хадгаламжийн данс нээх үйлчилгээ үзүүлэхдээ тэдгээрт холбогдох наад захын холбогдох мэдээллийг аваагүй, харилцагчийн хувийн хэргийн бүрдэл хангалтгүй байсан нь Монголбанкны газар дээрх хяналт шалгалт, Санхүүгийн мэдээллийн албаны хянан шалгагчийн шалгалтгаар тус тус тогтоогдсон байна. Зөрчсөн хууль, дүрэм, журмуудыг судалж, даалгаврыг хийнэ үү.

Шийдвэрлэх асуудал:

Өгөгдөл: Хувийн банкны алба нь Нина Ивановна, Ото Ямамота гэх 2 иргэнд их хэмжээний мөнгөн хөрөнгө бүхий хадгаламжийн данс нээх үйлчилгээ үзүүлэхдээ тэдгээрт холбогдох наад захын холбогдох мэдээллийг аваагүй, харилцагчийн хувийн хэргийн бүрдэл хангалтгүй.

Зөрчсөн хууль, дүрэм, журам	Заалт

Хяналтын асуулт:

1. Мөнгө угаах гэмт хэрэг ба эдийн засгийн аюулгүй байдлын талаар ярина уу.
2. Банк мөнгө угаалтанд өртөхгүй тулд ямар зарчим баримтлах ёстой вэ?
3. Харилцагчаа танин мэдэх, сэжигтэй харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах-мөнгөн угаах үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцүүлэг өрнүүлэх.

V БҮЛЭГ. АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ

Бүлгийн зорилго: Банкны зөрчил, төлбөрийн чадварын хүндрэл, бүтцийн өөрчлөлт хийх болон банкны дампуурлын эрх зүйн зохицуулалтын талаар танилцуулан, банкинд албадлагын арга хэмжээ авах, онцгой дэглэм тогтоох,



эрх хүлээн авахтай холбоотой харилцаанд хууль зүйн дүгнэлт өгөх чадварыг эзэмшүүлнэ.

СЭДЭВ 11. БАНКИНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ.

Хичээлийн зорилго: Банкинд хүлээлгэх зарим албадлагын арга хэмжээ, төрөл, онцгой дэглэм тогтоох, авах арга хэмжээ, бүрэн эрхт төлөөлөгчийн эрх, үүрэг, банкны эрх хүлээн авах, банкийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой онолын мэдлэг зэмшиж, холбогдох хууль тогтоомжийг зөв хэрэглэх чадвар эзэмшинэ.

Түлхүүр үг: Албадлын арга хэмжээ, онцгой дэглэм, бүрэн эрхт төлөөлөгч, эрх хүлээн авах, эрх хүлээн авагч

Нэг. Тойм лекц:

Банкинд авах албадлагын арга хэмжээ, төрөл

Монголбанк Төв банкны тухай хуулийн дагуу хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор банк байгуулах зөвшөөрөл банкинд олгох, түүний өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах болон үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм, журам шийдвэр гаргаж, хэрэгжилтэд хяналт тавина.

Банкны хууль тогтоомж болон Монголбанкны бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэрийг банк зөрчсөн тохиолдолд хуульд заасан албадлагын арга хэмжээ авна. Өөрийн хөрөнгийн аль нэг шаардлагыг 80 хүртэл хувиар хангаагүй банкны үйлдлийг ноцтой зөрчил гэж үзэн авах албадлагын арга хэмжээг хуульд тусгайлан зааж өгсөн байна. Банкны санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг “өөрийн хөрөнгийн хүрэлцээ” гэдэг.

Банкны хууль болон Монголбанкны шийдвэр зөрчсөн

Банкны тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан албадлага хэрэглэнэ.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээг 80 хүртэл хувиар хангаагүй

Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан тусгайлан албадлага хэрэглэнэ.


Монголбанк болон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадлагын арга хэмжээг авах нь банкыг бусад хуулиар хариуцлага хүлээхээс чөлөөлөх үндэслэл болохгүй юм. Мөн тухайн адилхан үйлдэл, эс үйлдэлд адил албадлагын арга хэмжээ авах зарчмыг баримтлана.

Монголбанк тухайн банкны гаргасан зөрчлийг шалгаж тогтоон зохих албадлагын арга хэмжээ авахаас гадна банкинд алдаагаа засах, зөрчлөө арилгах боломжийг олгосон зохицуулалт хуульд байдаг. Банк өөрийн хөрөнгийн шаардлага хангаагүй нөхцөл үүссэнээс хойш 14 хоногийн дотор өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээ зохистой хэмжээнд хүргэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж Монголбанкинд ирүүлнэ. Энэхүү төлөвлөгөөг Монголбанк хянаж хуульд заасан шаардлага хангасан бол хэрэгжүүлэх зөвшөөрөл өгнө.

Банкинд онцгой дэглэм тогтоох

Монголбанкнаас тогтоосон журмын заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг зохих хэмжээ, хэлбэрээр хангаагүй, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах шаардлагуудыг 3 сарын хугацаанд хангаагүйн улмаас төлбөрийн чадваргүй болж болзошгүй нь онцгой дэглэм тогтоох үндэслэл болно.

Энэ үндэслэлийг Монголбанк хяналт шалгалтаараа тогтоож өөрийн шийдвэрээрээ тухайн банкны хэвийн үйл ажиллагааг хангах, санхүүгийн байдлыг нь сайжруулах зорилгоор удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн болон холбогдох бусад арга хэмжээг цогцолбороор нь авч хэрэгжүүлэхийг онцгой дэглэм тогтоох гэнэ.



Монголбанк онцгой дэглэм тогтоосноор тухайн банкинд бүрэн эрхт төлөөлөгчийг 1 жил хүртэл хугацаагаар томилно. Онцгой дэглэм тогтоох тухай



Монголбанкны шийдвэрийн талаар банкны хувьцаа эзэмшигч 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

БЭТ нь үйл ажиллагаандаа банкны хууль тогтоомжийг мөрдөх ба тусгайлсан удирдамжтай байж дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- банкны бүх үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар бие даан шийдвэр гаргах;
- шаардлагатай гэж үзвэл онцгой дэглэм тогтоосон хугацаанд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй холбогдох үүргийг бүрмөсөн, эсхүл хэсэгчлэн биелүүлэхийг түдгэлзүүлэх;
- банкнаас урьд нь харилцагчтай хийсэн зээл, хадгаламжийн болон бусад гэрээний нөхцөл нь банкны тухайн үеийн ерөнхий нөхцөлөөс өөрөөр тогтоогдож, банкны эрх ашигт сөргөөр нөлөөлсөн гэж үзвэл уг гэрээнд өөрчлөлт оруулах, цуцлах;
- банкны нэрийн өмнөөс гэрээ байгуулах, нэхэмжлэл гаргах;
- банкнаасажилтантайбайгуулсанхөдөлмөрийнгэрээгцуцлах,түүндөөрчлөлт оруулах, шаардлагатай ажилтныг түр хугацаагаар авч ажиллуулах;
- банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангах зорилгоор түүний бүтэц, хэмжээг өөрчлөх;
- банкнийг өөрчлөн байгуулах төлөвлөгөө боловсруулах зэрэг болно.

Бүрэн эрхт төлөөлөгч 30 хоногийн дотор банкнийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөг боловсруулан Монголбанкинд хүргүүлнэ. Уг төлөвлөгөөг Монголбанк тав хоногийн дотор батална.

Банкны эрх хүлээн авах

Монголбанк нь банк, түүний удирдлагын бүрэн эрх болон банкны хөрөнгийг захиран зарцуулах эрхийг банкны эрх хүлээн авагчид шилжүүлэн банкинд бүтцийн өөрчлөлт хийх буюу банкнийг албадан татан буулгах үйл ажиллагааг банкны эрх хүлээн авах гэнэ.

Банкинд эрх хүлээн авах үндэслэл	
Онцгой дэглэм тогтоосон боловч хэвийн үйл ажиллагаа хангагдаагүй гэж Монголбанк үзвэл;	Банк төлбөрийн чадваргүй болсон.

Дор дурдсан нөхцөл байдлын аль нэг бүрдсэн тохиолдолд банкнийг төлбөрийн чадваргүй болсонд тооцно:

- банк хадгаламж эзэмшигч, харилцагч, бусад үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийн мөнгийг тэдний анхны шаардлагаар гарган өгч чадахгүй болсон;
- өөрийн хөрөнгийн аль нэг шаардлагыг 80-аас дээш хувиар хангаагүй нөхцөл үүссэн зэрэг болно.

Банкинд бүтцийн өөрчлөлт хийх нь албадан татан буулгаснаас нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хэмжээгээр хангах боломжтой гэж үзвэл Монголбанк тухайн банкинд бүтцийн өөрчлөлт хийх тухай шийдвэр гаргаж, бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө батална.

Банкинд бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө батлах боломжгүй гэж үзсэн, эсхүл бүтцийн өөрчлөлт хийх шийдвэр гарснаас хойш зургаан сарын дотор банкинд бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөө амжилтгүй хэрэгжсэн тохиолдолд Монголбанк банкныг албадан татан буулгах тухай шийдвэр гаргана.

Банкны эрх хүлээн авагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- банкны тодорхой үйл ажиллагааг үргэлжлүүлэх, зогсоох;
- банкны төлөх төлбөрийг зогсоох, төлбөрийн хэмжээг хязгаарлах;
- хадгаламжийн хүүгийн хувь хэмжээг тухайн үеийн хадгаламжийн хүүгийн доод хувь хэмжээнээс багагүй байхаар өөрчлөн тогтоох;
- банкны хөрөнгө оруулалт хийхээр байгуулсан гэрээг цуцлах, зээлийн хүү, үйлчилгээний хөлсний хувь хэмжээ, хугацаанд өөрчлөлт оруулах;
- банкны байгуулсан хөдөлмөрийн болон бусад гэрээг цуцлах, шаардлагатай ажилтан авч ажиллуулах;
- шаардлагатай гэж үзсэн мэдээллийг нийтэд мэдээлэх;
- банкны нэрийн өмнөөс гэрээ байгуулах;
- банкны нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд банкныг төлөөлөн оролцох;
- бусдад олгосон зээл болон зээлийн барьцаалсан эд хөрөнгийг үнэлж худалдах;
- банкны нэрийн өмнөөс Монголбанкнаас тогтоосон хэмжээг баримтлан төлбөр хийх.

Банкны эрх хүлээн авагч нь удирдлагын бүрэн эрх болон хөрөнгийг захиран зарцуулах эрхийг шилжүүлэн авсны дараа дараах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- банкны хувьцаа эзэмшигчдэд алдагдлыг хүлээлгэж, тэдгээрийн оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгө, бусад сангаас хасалт хийж санхүүгийн тайланд тусгах;



- банкны нийт актив хөрөнгийн жагсаалт, бүртгэлийг гаргах, активыг хяналтандаа авах;
- бусдын эзэмшилд байгаа банкны актив хөрөнгийг буцааж авах;
- хадгалалтын гэрээгээр авсан бусдын үнэт зүйлийг буцааж өгөх;
- банкинд бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөө буюу албадан татан буулгах санал, дүгнэлтийг гурван сарын дотор боловсруулж, Монголбанкинд танилцуулах.

Банкны мөнгөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоохоор Монгол Улсын Их Хурал 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг баталсан юм.

Хадгаламжийн даатгал гэдэг нь банкнаас харилцах болон хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгийг Хадгаламжийн даатгалын корпорацид даатгуулах, даатгалын тохиолдол бий болоход хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр төлөхтэй холбогдсон үйл ажиллагааг ойлгоно. Банк хадгаламж эзэмшигчийн хадгаламжийг заавал даатгуулж, даатгалын хураамж төлнө.

Банкны тухай хуульд заасан зохих журмын дагуу Монголбанк банкиг албадан татан буулгах шийдвэр гаргаснаар хадгаламж эзэмшигчид Хадгаламжийн даатгалын корпорациас даатгалын нөхөн төлбөрөө шаардах эрх үүснэ.

Банкийг албадан татан буулгах тухай шийдвэр гарсан тохиолдолд банкны эрх хүлээн авагч нь дараах арга хэмжээ авна:

- худалдаж борлуулах актив хөрөнгийн жагсаалт, түүнийг борлуулах үнэлгээг тогтоож, холбогдох этгээдэд мэдээлэх;
- банкнаас авлагатай этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авах хугацааг тогтоож, нийтэд мэдээлэх;
- нэхэмжлэлийг хангах хэлбэр, хэмжээ, төлбөрийн хуваарь, дарааллыг тогтоож, нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш хоёр сарын дотор холбогдох нэхэмжлэгчид мэдэгдэх.

Актив хөрөнгийг худалдаж борлуулсны орлого нэхэмжлэлийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол дарааллын эхний төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн дарааллын төлбөрийн шаардлагыг хангана. Нэг дараалалд орсон хэд хэдэн төлбөрийг нэгэн зэрэг барагдуулж хүрэлцэхгүй бол тус бүрийн төлбөрийн хэмжээнд хувь тэнцүүлэн нэхэмжлэлийн шаардлагыг хангана.

Төлбөрийг бүрэн барагдуулсаны дараа үлдэх эд хөрөнгийг тухайн банкны хувьцаа эзэмшигчдэд хувьцааны давуу ба ердийн эрх гэсэн дарааллаар хувь тэнцүүлэн хуваарилна.

Банкны эрх хүлээн авагч нь банкинд бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөөг хэрэгжүүлсэн болон нийт актив хөрөнгийг худалдан борлуулж дууссан тухай тайланг Монголбанкинд ирүүлснийг, Монголбанк баталж, нийтэд мэдэгдсэнээр банкны эрх хүлээн авах ажиллагааг дуусгавар болсонд тооцно. Банкны дампуурлыг шүүх зарлаж, дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Хоёр. Семинар

Банкинд хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээ, онцгой дэглэм тогтоох, банкны эрх хүлээн авахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл, материал бэлдэнэ. Оюутануудыг 4 бүлэгт хуваана. Бүлгийн гишүүд хуваарилсан мэдээлэл, материалыг судлан үзэж, хүснэгтэд тусгасан шалгуураар тухайн мэдээлэл, материалд боловсруулалт хийж, хэлэлцүүлэг хийнэ үү.

Шалгуур	Банкны тухай хуулийн 46 дугаар зүйл	Банкны тухай хуулийн 48 дугаар зүйл	Онцгой дэглэм тогтоох	Банкны эрх хүлээн авах
үндэслэл				
албадлагын арга хэмжээний төрөл				
албадлагын арга хэмжээ авах журам, шийдвэр				
банкны хэрэгжүүлэх төлөвлөгөө				
тухайн банкинд үүсэх үр дагавар				

Хяналтын асуулт:

1. Банкны эрх хүлээн авагч, бүрэн эрх төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлно уу?
2. Банкны эрх хүлээн авагч банкны активыг худалдан борлуулсны орлогоос нэхэмжлэгчийн шаардлагыг ямар дарааллыг баримтлан хангах вэ?



III ХЭСЭГ. БАНКНЫ ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ЗААХ АРГА ЗҮЙ

1. Хичээлийн заах арга зүйд тавигдах шаардлага

Банкны эрхзүй хичээлийг оюутанд мэдлэг, чадвар, хандлага болгон эзэмшүүлэхийн тулд дараах ерөнхий шаардлагад тулгуурласан арга зүйг баримтлана. Үүнд:

- Хичээлийн агуулга, хэлбэрт тохирсон арга зүйг ашиглан мэдлэг олгох;
- Оюутныг бүтээлчээр хандах, хичээлийн агуулга оюутан бүрт хүртээмжтэй байх;

Багш хичээлийн сэдвийн зорилгыг хангах хүрээнд доорх арга зүйн аль тохирохыг сонгон авах эрхийг үлдээж байна. Гэхдээ санал болгож буй эдгээр арга зүй, түүнийг хэрэгжүүлэх дараалал нь туйлын шинжтэй биш бөгөөд нөхцөл байдалдаа тохируулан нэмж баяжуулан ашиглах боломжтой юм.

2. Банкны эрх зүй хичээлд хэрэглэгдэх зарим арга зүй

Лекцийн арга (Lecture)

Хичээлийг сэдвийн үндсэн агуулгатай холбоотой мэдээллийг оюутнуудад түгээхэд “лекцийн арга” түлхүү хэрэглэгдэнэ. Оюутанд хамгийн гол мэдээлэл өгөх, мөн онолын хувьд маргаантай, тухайн сэдвээр хэрэглэгдэх материал хангалттай биш асуудалд дүгнэлт өгсөн байдлаар боловсруулсан мэдээллийг хүргэхийг зорино. Энэ арга оюутанд сонсох болон асуудлыг хэрхэн тодорхойлж, томъёолох чадварыг эзэмшүүлэхэд оршдог.

Лекцийн аргыг хэрэглэх явцад дараах зүйлийг анхаарвал зохино. Үүнд:

- Лекцийнхээ сэдвийн агуулгыг танилцуулж, сэдвийн хүрээнд ямар асуудлыг хөндөх дэд сэдвүүдийг дурьдаж, лекцийн зорилго, түүний төгсгөлийн үр дүнг танилцуулах хэрэгтэй.
- Хүний анхаарал төвлөрөх дундаж хугацаа 15-20 минут байдаг. Иймд 15-20 минут лекц уншаад түр завсарлага авах, оюутнуудын анхаарал төвлөрөлт хэр байгааг хялбархан асуулт тавих байдлаар мэдэх, эсвэл тухайн сэдэвтэй холбоотойгоор бяцхан хошигнол, сонирхолтой яриа өрнүүлж тэдний идэвхийг сэргээж, цааш нь лекцийг үргэлжлүүлэх нь зүйтэй.
- Оюутнуудын тоо, ангийн багтаамжийг харгалзан тухайн сэдвийн аль хэсгийг ярих, аль хэсгийг бичүүлж тэмдэглүүлэх вэ гэдгийг үнэлж, тохирох хувилбарыг сонгох нь зүйтэй.
- Тухайн сэдвийн хүрээг бүхэлд нь хамрахад цаг хугацааны хувьд багтаамж муутай байдаг Иймд богино хугацаанд тухайн сэдвийн зорилгод заасан үр

дүнд хүрэхийн тулд дэлгэрүүлэн унших, судлах сурах бичиг, ном, сэтгүүл, гарын авлага цахим хуудасны жагсаалтыг тухайлсан асуудал бүрт өгч байх, түүнчлэн үзүүлэн таниулах материал, бүдүүвч, схем, диаграммыг ашиглах, гэрэлт самбар болон бусад тоног төхөөрөмжийн тусламжтайгаар бага хугацаанд их хэмжээний мэдээллийг хүргэхэд анхаарах нь зүйтэй.

- Банкны ажил үйлчилгээ хүн бүхэнд хүртээмжтэй болсон энэ үед мэдээллийн үр дүн, ач холбогдлыг нэмэгдүүлэх, оюутныг цаашид бие даан суралцах идэвхи, сонирхлыг нэмэгдүүлэхийн тулд лекцийн мэдээллийн тодорхой хувийг сонирхолтой, үндэслэлтэй, онцгой тоо баримт, жишээ, тухайн үед болж буй мэдээлэл, тохиолдлыг лекцийн агуулгыг алдагдуулахгүйгээр хэрэглэх нь зүйтэй байх.
- Лекцийн төгсгөлд тухайн сэдвийн ач холбогдол, хүртээмжтэй, ойлгомжтой байсныг хөнгөн хялбар, тухайн үед нь шууд хариулах боломжтой асуудлаар шалгах нь зүйтэй.

Эвлүүлгийн арга (Jacksaw)

Энэ арга нь богино хугацаанд их мэдээлэл олж авах, оюутнууд нэр томъёо, үндсэн ойлголтуудыг тайлбарлах, асуулт асуух, бусадтай харилцах замаар бие биедээ сургах боломж олгодог.

Хэрэгжүүлэх дараалал:

1. Зарим сэдвээр өгөх мэдээллийн багтаамж их байдаг. Багш шаардлагатай мэдээлэл болон нэмэлт хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлдсэн байна.
2. Багш багийг (1,2,3-аар тоолуулан) бүрдүүлнэ. Баг бүрийн гишүүн тус бүр өөр өөр өнгийн цаастай байна. (нэг нь улаан, нөгөө нь цэнхэр, гурав дахь ногоон, дөрөв дэх нь шар г.м) Бэлтгэсэн материалаа багуудад тараан өгөх болно.
3. Багийн гишүүд одоо шинэ газар очиж, эрдэм сурч ирээд бие биедээ сурсан эрдмээ заах болно гэдгийг хэлээд баг бүрт байгаа адил өнгийн цаастай хүмүүсийг дахин шинэ баг үүсгэхийг хүснэ. Оюутан “мэргэжилтнүүдийн” багт шилжин мэдээлэл олж авна.
4. “Мэргэжилтнүүд”-ийн багаас өөрийн багтаа буцаж ирнэ. Мэргэжилтний багт ямар мэдээлэл авсан, юу сурсанаа багийн гишүүддээ нэг нэгээрээ зааж өгнө.
5. Багш ойлгосон эсэхийг шалгаад дүгнэнэ.

Хүн бүр багш (Each one teach one)

Хичээлийн үйлэвцэд идэвхитэй оролцох, бие биетэйгээ санаа бодлоо солилцоход ихээхэн ач холбогдолтой. Тухайн сэдвийн хүрээнд заавал эзэмших ёстой агуулга, ойлголтын талаар ерөнхий мэдээлэл өгнө.



Хэрэгжүүлэх дараалал:

1. Мэдээллийг утгат хэсгээр хувааж, оюутнуудад тарааж өгнө. Оюутан мэдээлэлтэй танилцсаны дараа уншсан зүйлийн агуулгыг ярих, зураглал, бүдүүвчээр илэрхийлэх зэргээр бусдад түгээх бэлтгэлээ хийнэ.
2. Бэлтгэж дууссаны дараа оюутан бүр өөрт байгаа мэдээллээ танилцуулж, бусдаас мэдээлэл авч дуустал үргэлжилнэ. Энэ нь өөрт буй мэдээллээ бусдад ойлгуулах, бусдаас шинэ мэдээлэл олж авах ач холбогдолтой.
3. Үүний дараа багш юу мэдсэн, ямар мэдээлэл олж авсан, мэдээллийг юу гэж ойлгож байгаа тухай, энэ мэдлэг нь оюутанд ямар ач холбогдолтой талаар чөлөөтэй ярилцлага зохион байгуулна.
4. Ярилцлагын явцад оюутны ойлгоогүй зүйл дээр нэмэлт мэдээлэл өгөх боломж бий болно.

Байр сууриа илэрхийлэх арга

Тодорхой сэдвийн хүрээнд эсрэг тэсрэг байр суурь бүхий асуудлыг сонгон авч оюутанд өөрийн байр сууриа илэрхийлэх болон харилцааны чадвараа амьдралд хэрэглэх боломж олгох боломжтой.

Хэрэгжүүлэх дараалал:

1. Ангид сэдвээс хамааран “Санал бүрэн нийлж байна”, “Санал бүрэн нийлэхгүй байна” эсвэл “Маш зөв”, “Зөв”, “Шийдээгүй буюу эргэлзэж байна”, “Буруу”, “Маш буруу” гэсэн агуулгатай цаасыг байрлуулна.
2. Энэ аргаар ажиллахад хичээл хэрхэн явагдах дүрэм зохиож түүнийгээ хэлэлцэн батална. Жишээлбэл:
 - Хэлэлцэж буй асуудлын хүрээнд өөрийн байр суурь нэг байгаа бичиг бүхий буланд очиж зогсоно.
 - Оюутныг байр сууриа тодруулж тайлбарлахыг хүснэ. Бүх оюутныг хамруулах үүднээс ижил сонголттой нь нэг баг үүсгэж хэлэлцэж байр сууриа танилцуулахад бэлдэнэ.
 - Хүн бүрийн байр сууриа илэрхийлсэний дараа хэн нэгний байр сууриа өөрчлөгдсөн эсэхийг асууна.
 - Эсрэг байр суурьтай үндэслэлээс хамгийн үнэмшилтэй байсныг асууна.

Хэрэг шинжлэх (Case method)

Банкны эрх зүйн хэмжээг амьдралын тодорхой жишээн дээр үндэслэн хэрэглэж сурахад чиглэсэн арга юм. Тодорхой жишээ нь банкны системд болсон бодит хэрэг, зохиомол үйл явдал, шүүхийн шийдвэр, тодорхой гэрээ зэрэг оюутанд шинэ ойлголт мэдлэг өгөх, асуудалд олон талаас шүүмжлэлтэй, нухацтай хандах сэтгэлгээг

хөгжүүлэхэд чиглэгдсэн хэрэглэгдэхүүн юм. Хэрэг шинжлэх аргыг хэрэглэхэд холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт болон гарын авлагуудыг бэлтгэсэн байх шаардлагатай бөгөөд хангагдаагүй тохиолдолд хичээлийг үр дүнтэй явуулах боломжгүй.

Хичээлийн хэрэглэгдэхүүн болох бодлого, тохиолдол нь баялаг агуулгатай, өгөөжтэй, оюутны дадлага, чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстой.

Хичээлд 20-оос илүүгүй оюутан хамгийн боломжтой бөгөөд илүү оюутантай багш нэгэн зэрэг ажиллах нь тохиолдолд хичээлийн зорилго, үр дүнд муугаар нөлөөлж болзошгүй.

Хэрэгжүүлэх дараалал:

- Бодлого, тохиолдол, хэрэг маргааныг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг өгөх. Мэдээллийг өгөх олон янзын арга байдаг. Тухайлбал, уншуулах, бага хэмжээний лекц сонсох, видео бичлэг үзэх г.м.
- Бодлого, тохиолдол, хэрэг маргааныг уншуулах. Энэ оюутанд бодлого, тохиолдлын эцсийн үр дүн, шийдвэрийг мэдээлэхгүй байх хэрэгтэй.
- Оюутанд бодлого, тохиолдлын үйл явдлыг сайтар ойлгуулах нь чухал. Тухайлбал, дараах асуулт тавих замаар тэдний ойлголтыг гүнзгийрүүлж болно.
 - Чухам яг ямар үйл баримт болсон бэ?
 - Ямар хүмүүс, талууд оролцсон болох?
 - Оролцогчид ямар үйлдлийг ямар учир шалтгааны улмаас үйлдсэн болох?
 - Ямар үйл баримт чухал болох, ямар баримт, юу дутагдаж байна вэ?
 - Багшийн зүгээс өөрөө асуулт боловсруулан оюутанд тавих эсхүл тэднээр өөрсдөөр нь асуулт боловсруулж болох юм.
- Оюутан хэрэгтэй мэдээллээ авч, тохиолдлыг хангалттай сайн судалж, ойлгосны үндсэн дээр шийдвэр гаргах үйл ажиллагаандаа орно. Тэдний шийдвэр гаргах үйл явцыг багш олон аргаар зохион байгуулж болно.